Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн..................дугаар албан бичгийн хавсралт



CITY OF NOMADS

# НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| МУ | Монгол Улс |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЗГ | Засгийн газар |
| СЯ | Сангийн яам |
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| НТАЗ | Нийслэл дэх Төрийн албаны зөвлөл |
| ХШҮГ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ХБТГ | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар |
| ТЗУГ | Төрийн захиргааны удирдлагын газар |
| НХААГ | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар |
| ТХААХ | Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтэс |
| ЗСХ | Захиргаа, санхүүгийн хэлтэс |
| МТХ | Мэдээллийн технологийн хэлтэс |
| ХЭЗХ | Хууль, эрх зүйн хэлтэс |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НДАА | Нийслэлийн Дотоод аудитын алба |
| НӨХГ | Нийслэлийн Өмчийн харилцааны газар |
| НЭМГ | Нийслэлийн Эрүүл мэндийн газар |
| НАГ | Нийслэлийн Архивын газар |
| БГД | Баянгол дүүрэг |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНД | Багануур дүүрэг |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| БХД | Багахангай дүүрэг |
| НД | Налайх дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| ХАСХОМ | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг |
| ХАСХУМ | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг |
| ЭБАТ | Эрх бүхий албан тушаалтан |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТБОНӨХБАУХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХХНЖ | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт |
| БНШК | Баримт нягтлан шалгах комисс |
| ЭШТБ | Эрдэм шинжилгээ техник боловсруулалт |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТӨХ | Тендерийн өгөгдлийн хүснэгт |

# АГУУЛГА

АГУУЛГА ........ 3
НЭГ.НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.. 6
1.1.Уриа ........ 6
1.2.Алсын хараа ........ 6
1.3.Эрхэм зорилго ........ 6
1.4.Үнэт зүйл ........ 6
1.5.Үндсэн чиг үүрэг ........ 6
1.6.Бүтэц, орон тоо ........ 6
ХОЁР.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ........ 7
2.1.Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ ........ 7
2.2.Дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүн ........ 8
2.2.1.Бодлогын баримт бичигт тусгагдсан тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилт, үр дүн ........ 8
2.2.2.1."Төрийн худалдан авах ажиллаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ." гэсэн арга хэмжээний хэрэгжилт ........ 9
2.2.2.2.Орон нутгийн ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд ........ 9
2.2.3.Газрын хяналтад буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан талаар ........ 10
ГУРАВ.ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ........ 10
3.1.Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт ........ 10
3.2.Зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил ........ 12
3.3.Үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл ........ 12
3.3.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл ........ 12
3.3.2.Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III хэрэгжилт, үр дүн ........ 16
3.3.3."Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр" биелэлт, үр дүн .... 17
ДӨРӨВ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ........ 20
4.1.Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл ........ 20
4.1.1.Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах чиг үүргийн хүрээнд ........ 20
4.1.2.Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд ........ 22
4.1.3.Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системээр батлуулах, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эрх шилжүүлэх,

төлөвлөгөө батлах ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд ... 22
4.2.Байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл ... 29
4.2.1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилт ... 29
4.2.2.Албан хаагчид мэдлэг чадвар дээшлүүлсэн байдал ... 31
ТАВ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ... 33
ЗУРГАА.БУСАД МЭДЭЭЛЭЛ ... 34
6.1.Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл ... 34
6.2.Нийслэлийн хэмжээнд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн ... 34
6.3.ННЗБ-уудад сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил ... 42
6.3.1.СУРГАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮН МЭДЭЭ ... 47
ДОЛОО.ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ... 48
7.1.Дотоодын аудитын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил ... 48
7.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглээр хийсэн ажил ... 49
НАЙМ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ... 51
8.1.Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил ... 51
8.1.1.Архивын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил ... 51
8.1.2.Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил ... 52
8.1.3.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл ... 53
8.2.Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд ... 56
ЕС.БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ЗӨВЛӨЛ, КОМИССУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ... 58
9.1.Эцэг, эхийн зөвлөл ... 58
9.2.Соёл урлаг спортын зөвлөл ... 59
9.3.Ёс зүйн дэд хороо ... 62
9.4.Залуучуудын Хөгжлийн Зөвлөл ... 66
9.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хийж гүйцэтгэсэн ажил ... 68
АРАВ.БУСАД АРГА ХЭМЖЭЭ ... 78
10.1.Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр оролцох. ... 78
10.2.“Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд: ... 79

# НЭГ.НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1.Уриа

Бидний үйлдэл-Бидний ирээдүй.

## 1.2.Алсын хараа

Нийслэлийн бүтээн байгуулалтад манлайлан оролцогч мэргэшсэн байгууллага байна.

## 1.3.Эрхэм зорилго

Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулахад оршино.

## 1.4.Үнэт зүйл

-Мэргэшсэн албан хаагчид,
-Байгууллагын нэр хүнд.

## 1.5.Үндсэн чиг үүрэг

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь дарга, 4 хэлтэс нийт 40 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ба газрын үйл ажиллагаанд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1.Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх;

3.Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг цахим системээр батлуулах, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эрх шилжүүлэх, төлөвлөгөө батлах ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх.

## 1.6.Бүтэц, орон тоо

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1059 дүгээр захирамжийн хавсралтаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг зохион байгуулалтын 5 нэгж, 41 орон тоотойгоор баталсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу орлогч даргын орон тоо хасагдаж, 40 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” А/1128 дугаар захирамжаар НХААГ-ын бүтцээс “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлтэс”-ийг хасаж, чиг үүргийг “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-д шилжүүлсэн тул 4 нэгж, 40 орон тоотой болж шинэчлэгдсэн.

Албан тушаалын жагсаалтыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай” А/116 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлж ажилласан. Үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан газрын дүрмийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/1205 дугаар захирамжаар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зураг 1. Удирдлага, зохион байгуулалтын бүтэц

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Бүтцийн схем




## ХОЁР.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 2.1.Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт дараах арга хэмжээнүүд тусгагдаж, Үүнд:

1.”Төрийн худалдан авах ажиллаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх.” гэсэн арга хэмжээ нь:

- ✓ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.1.7-д “Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ”;
- ✓ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.1.5-д “Төрийн худалдан авах ажиллагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлсэн байна” гэж тусган нийслэлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувийг 2025 онд 11 хувьд хүргэхээр;
- ✓ Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 228 дугаарт “Төрийн худалдан авах ажиллаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх” 2025 онд нийслэлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 11 хувьд хүрсэн байна гэж тус тус тусгасан. Хөтөлбөрийн үр дүнг “Нийслэлийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлнэ” гэж тодорхойлсон.

2.”Орон нутгийн ногоон худалдан авалтыг нэмэгдүүлнэ.” гэсэн арга хэмжээ нь:

- ✓ ”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.6-д “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ” гэж тусгаад Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг 2025 онд 10 хувь, 2030 онд 20 хувь, 2050 онд 50 хувьд хүргэхээр төлөвлөсөн.
- ✓ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.5-д “Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлж, 20 хувьд хүргэнэ” гэж тусгаад 2025 онд орон нутгийн ногоон худалдан авалтыг нийт худалдан авалтын 11 хувьд хүргэхээр тус тус тусгасан.

Зураг 2. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт




## 2.2.Дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

### 2.2.1.Бодлогын баримт бичигт тусгагдсан тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

Байгууллагын хяналтад авсан дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээ буюу ногоон худалдан авалт болон дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан тухай тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт нэгдүгээр улирлын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 02/891 дүгээр албан бичгээр, хоёрдугаар улирлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 02/1818 дугаар албан бичгээр, жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 02/2805 дугаар албан бичгээр тус тус 3 удаа тайлагнаж ажилласан.

#### 2.2.1.1.“Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжих” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Нийслэлийн хэмжээнд бодлогын баримт бичиг тайлагнах үеийн байдлаар нийт 16,958,854,627,434 (арван зургаан их наяд есөн зуун тавин найман тэрбум найман зуун тавин дөрвөн сая зургаан зуун хорин долоон мянга дөрвөн зуун гучин дөрөв) төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 5,600,634,362,929 (таван их наяд зургаан зуун тэрбум зургаан зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран хоёр мянга есөн зуун хорин ес) төгрөгийн санхүүжих дүнтэй 1748 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

Үүнээс 259 төсөл, арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д заасан бараанаас нутгийн захиргааны 51 байгууллага дотоодын үйлдвэрлэгч 155 байгууллагаас бараа бүтээгдэхүүний ерөнхий ангиллын 16 нэр төрлийн 93,111,570,510.0 (ерэн гурван тэрбум нэг зуун арван нэгэн сая таван зуун далан мянга таван зуун арав) төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна. Энэ нь тухайн жилийн зорилтот түвшний 11 хувьд хүрсэн байна.

График 1. Нийслэлийн хэмжээнд дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан (2021-2025 он)



### 2.2.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл хэрэгжилт, үр дүн

Нийслэлийн нутгийн захиргааны 51 байгууллага 93 тэрбум төгрөгийн дотоодын худалдан авалт хийсэн нь зорилтот түвшний 11 хувийг эзэлж байна.

#### 2.2.2.1. "Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ." гэсэн арга хэмжээний хэрэгжилт

Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 16,958,854,627,434 (арван зургаан их наяд есөн зуун тавин найман тэрбум найман зуун тавин дөрвөн сая зургаан зуун хорин долоон мянга дөрвөн зуун гучин дөрөв) төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 5,600,634,362,929 (таван их наяд зургаан зуун тэрбум зургаан зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран хоёр мянга есөн зуун хорин ес) төгрөгийн санхүүжих дүнтэй 1748 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

Үүнээс 259 төсөл, арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д заасан бараанаас нутгийн захиргааны 51 байгууллага дотоодын үйлдвэрлэгч 155 байгууллагаас бараа бүтээгдэхүүний ерөнхий ангиллын 16 нэр төрлийн 93,111,570,510.0 (ерэн гурван тэрбум нэг зуун арван нэгэн сая таван зуун далан мянга таван зуун арав) төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна.

Энэ нь зорилтот түвшний 11 хувийг эзэлж байна.

#### 2.2.2.2.Орон нутгийн ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд

”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.6-д “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ” гэж тусгаад Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг 2025 онд 10 хувь, 2030 онд 20 хувь, 2050 онд 50 хувьд хүргэхээр төлөвлөсөн.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.5-д “Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлж, 20 хувьд хүргэнэ”.

Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 16,958,854,627,434 төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 5,600,634,362,929 төгрөгийн санхүүжих дүнтэй 1748 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс: Нийслэлийн нутгийн захиргааны 57 байгууллага 271 төсөл, арга хэмжээнд ногоон худалдан авалт хийсэн зорилтот түвшний 11 хувийг эзэлж байна.

Нийслэлийн хэмжээний ногоон худалдан авалт хийсэн тайлан
(2021-2025 он)



### 2.2.3. Газрын хяналтад буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан талаар

Байгууллагын хяналтад авсан дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээний буюу ногоон худалдан авалт болон дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан тухай тайланг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас авч нэгтгэн, хяналт-шинжилгээг 2 удаа хийж, 100 хувийн гүйцэтгэлтэй буюу "Үр дүнтэй" дүгнэгдэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 02/891 дугээр албан бичгээр, хоёрдугаар улирлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 02/1818 дугаар албан бичгээр, жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 02/2805 дугаар албан бичгээр тус тус 3 удаа тайлагнаж ажилласан.


ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭД БҮТЭЦ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭСТ

Биелэлт хүргүүлэх тухай

Тус газраас Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилт, танилцуулга, холбогдох нотлох баримтыг хавсралтаар хүргүүлж байна.

1 дүгээр хавсралт: Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт, 3 хуудастай.
2 дугаар хавсралт: Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 3 хуудастай.
3 дугаар хавсралт: Нэгтгэл, 69 хуудастай.
4 дүгээр хавсралт: Хурлын тэмдэглэл, 2 хуудастай.
5 дугаар хавсралт: Зөвлөмж, 4 хуудастай.
6 дугаар хавсралт: Танилцуулга, 1 хуудастай.

2025.12.01 14:00

## ГУРАВ.ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

### 3.1.Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 126 хууль тогтоомж, тогтоол шийдвэр хяналтад авч, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын 4 хууль;
- Ерөнхийлөгчийн 4 зарлиг;
- Засгийн газрын 11 тогтоол;
- Засгийн газрын хуралдааны 3 тэмдэглэл;
- Засгийн газар болон Ерөнхий сайдын 4 албан даалгавар;
- Сангийн сайдын 1 тушаал;
- Монгол Улсын Эдийн засаг, Хөгжлийн сайдын 2 тушаал;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 1 тогтоол;
- Нийслэлийн Засаг даргын 1 албан даалгавар;
- Нийслэлийн Засаг даргын 20 захирамж;
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 5 хуралдааны тэмдэглэл;
- Худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн 70 захирамж нийт 126 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хамаарах нэгж, албан хаагчдад тухай бүр хүргүүлэн ажилласан.

Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 28, 04 дүгээр сарын 04, 2025 оны 06 дугаар сарын 23, 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 4 удаа ERP цахим системээр НЗДТГ-ийн ХШҮГ-т тайлагнасан.

Засгийн газрын 01, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг 8, 9, 10, 11 дүгээр сард НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын газарт (02/2326, 02/2507, 02/2631, 02/2769 дугаар албан бичгээр) тус тус тайлагнаж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 23 болон 10 дугаар сарын 14-ний өдөр, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, НЗД-ын

2025 оны А/62 дугаар “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийн биелэлтийг 1-12 дугаар сард UBERP цахимаар НЗДТГ-ын ХШҮГ-т 12 удаа тайлагнасан.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн захирамжийн хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 02/1977 дугаар албан бичгээр, жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02/2934 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт тайлагнасан.



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАРТ

Биелэлт хүргүүлэх тухай

Тус газраас хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлж байна.

1 дүгээр хавсралт: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, 41 хуудастай.
2 дугаар хавсралт: Эрх шилжүүлсэн захирамжийн биелэлт, 99 хуудастай.
3 дугаар хавсралт: Эрх шилжүүлсэн захирамжийн тайлан, 13 хуудастай.
4 дүгээр хавсралт: Хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмж, 3 хуудастай.
5 дугаар хавсралт: Хурлын тэмдэглэл, 3 хуудастай.

2025.12.26 16:11

Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн даруйд газрын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/07 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн үнэлгээний хороог ажлын 1-3 хоногийн дотор хууль тогтоомжид нийцүүлэн тушаалаар байгуулж байна. Нийслэлийн Засаг даргаас захирамжаар 2024 оны эрх шилжсэн 1, 2025 оны эрх шилжсэн 58 захирамж, 3 албан хүсэлтээр 401 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Газрын даргын 65 тушаалаар 118 үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо байгуулах дундаж хугацаа 2.6 хоног байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн 25 удаа хуралдаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн тус газарт хамаарал бүхий 102 үүрэг даалгаврын дундаж хэрэгжилт 96 хувь буюу нийт 25 удаа UBERP Хяналт-шинжилгээ үнэлгээ цахим системд хугацаанд нь тайлагнан ажилласан.



Хяналт шинжилгээ үнэлгээ

Б.ЧИНЗОРИГ

Файл тайлан

Тайлангийн жагсаалт

| № | Ангилал | Загвар | Тайлан | Дэд тайлан | Байгууллага | Төлөв | Дүгнэлтийн хувь төлөв | Төрийн байгууллагын дүгнэлтийн хувь | Төрийн байгууллагын дүгнэлтийн хувь (төлөв) | Тэгсэх огноо | Тайлан хүргүүлсэн огноо | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | Хайлт | |
| 42 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр | Хууль загвар 1 | 2025-04-14 | 2025-04-14 | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | ТАЙЛАН БА... | Хэрэгжээгүй | 100% | Бүрэн хэрэгжсэн | 2025-04-23 23 59 | 2025-04-23 15 01 | Дэлгэрэнгүй |
| 43 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр | Хууль загвар 1 | 2025-04-29 | Үүрэг даалгавар | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | ТАЙЛАН БА... | Хэрэгжээгүй | 91.83% | Бүрэн хэрэгжсэн | 2025 05-07 23 59 | 2025-05-07 15 07 | Дэлгэрэнгүй |
| 44 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр | Хууль загвар 1 | 2025-05-12 | Шуурхайн үүрэг даалгавар | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | ТАЙЛАН БА... | Хэрэгжээгүй | 100% | Бүрэн хэрэгжсэн | 2025 05-21 23 59 | 2025-05-20 11 39 | Дэлгэрэнгүй |

2025 оны жилийн эцсийн байдлаар “Удирдлагын зөвлөлийн хурал” 15 удаа хуралдсан бөгөөд нийт 58 үүрэг даалгаврыг өгснөөс дундаж хэрэгжилт 95 хувь байна.

## 3.2. Зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар 2025 оныг "Бүтээн байгуулалтын жил" болгон зарласан.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/01

2025 оныг "Бүтээн байгуулалтын жил" болгон зарлах тухай

Тус ажлын хүрээнд нийслэлийн бүтээн байгуулалтын 2025 оны төсөл, арга хэмжээний ажлын календарьчилсан төлөвлөгөөнд худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр НЗДТГ-т цахимаар хүргүүлсэн.

Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд тус газарт 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн 197 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж байна. Явц үр дүнг харуулбал:

- Гэрээ хийгдсэн -122;
- Гэрээ байгуулах эрх олгосон -55;
- Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа -1;
- Тендерийн материал хүлээн авч байгаа -1;
- Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа -3;
- Захирамжаар хүчингүй болсон- 15 арга хэмжээ байна.

Нийт 197 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын зарлал 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үр дүн гарсан 97 хувьтай, дундаж хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт болох захирамжийн түүврийг ERP цахимаар НЗДТГ-ын ХШҮГ-ын мэргэжилтэн (Б.Аюуш)-т 2 удаа тайлагнасан. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт болох захирамжийн түүврийг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр НЗДТГ-ын ХШҮГ-т 1 удаа ERP цахимаар тайлагнасан.

## 3.3.Үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган биелүүлэх чиглэлээр дараах ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

### 3.3.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/393 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө" болон арга хэмжээнд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын төлөвлөгөөг батлахдаа албан хаагчдаас санал авч, 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/56 дугаар тушаалын хавсралтаар 5 чиглэлийн 16 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 03 дугаар сарын ...ны өдрийн А/56 дугаар тушаалын хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**
**АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025 оны 03 дугаар сарын 27 Улаанбаатар хот

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулан олон нийтэд хүргэх; | -Баримтжуулсан байх; -Үр дүнг тооцож, тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо); | Жилдээ | ЭБАТ |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; | -Нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | ЭБАТ, ХЭЗХ, Нийт албан хаагчид |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагаар мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | -Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | Жилдээ | ЭБАТ |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагаар авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн | Жилдээ | ЭБАТ, Ёс зүйн дэд хороо, ХЭЗХ, МТХ |

Байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn)-т Авлигын эсрэг цэсэнд Авлигатай тэмцэх газар (iaac.mn) цахим хуудсыг холбосон.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас (ub-procurement.mn) болон “Нийслэлийн Худалдан Авах Ажиллагааны Газар” нэртэй фейсбүүк пейж хуудсаар дамжуулан авлигын хор хөнөөл, шүгэл үлээх, авлигыг мэдээлэх 110 дугаарыг иргэд, олон нийтэд сурталчилсан 7 удаагийн постер, 3 видео мэдээ, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан мөрдөгддөг хууль тогтоомжид заасан авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллагын чиг үүргийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.







Авлигыг мэдээлэх 110 дугаарыг:

Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн “UB ERP” систем, Байгууллагын веб хуудас (ub-procurement.mn), “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” нэртэй албан ёсны фейсбүүк пейж хуудасны нүүр хэсэгт оруулж цахим хуудсанд хандаж байгаа иргэд, олон нийт шууд танилцах боломжтойгоор байршуулсан.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны “Шудрага ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбар”-ыг ажиллуулж байна.







Байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn)-т байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтээ илгээх боломжтой талбарыг нээсэн.







Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим систем (tender.gov.mn)-ээр 100 хувь зохион байгуулж, тендер шалгаруулалтад хүний оролцоог бууруулан гэрээ байгуулах эрх олгосон өдөртөө багтаан шалгарсан тендерт оролцогчийн материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгон ажиллаж байна.




Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах, Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:











Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан Нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллагын худалдан авах ажиллагаа хариуцсан 51 албан хаагчид 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн практик хэрэглээ” сэдэвт сургалтад “Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар таниулан сурталчилж, мэдээлэл өгч ажилласан.

Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02/1918 дугаар албан бичгээр, жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/2870 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.

### 3.3.2.Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III хэрэгжилт, үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 96 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хүрээнд байгууллагын албан хаагчид үндэсний бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сургалтад сууж, бие даан ном, сурах бичиг, видео хичээл үзэж, суралцаж байна.

Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилгын “Б” блок байранд харьяа байгууллагуудыг нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022 онд батлагдсан “Төрийн байгууллагын нэрийн тэмдэг” хотын стандартын дагуу төрийн байгууллага өөрийн нэрийн тэмдгийг байрлаж буй барилга, ажлын байрныхаа гадна талд төв хаалга, орцны орчимд иргэдэд ойлгомжтой, ил тод харагдах байдлаар байршуулна гэсний дагуу байгууллагын гадна хаяг, дотор хэлтэс, нэгжийн өрөө тасалгааны хаягийг кирилл, үндэсний бичгийг хослуулан шинэчлэн хийлгэсэн.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 2025/06 дугаартай гэрээг “Эрдмийн гүүр эхлэл” ТББ-ын захирал Б.Болорсайхантай байгуулж, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 30 цагийн анхан, дунд шатны танхимын сургалтад 32 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцан, шалгалт өгч, 06 дугаар сарын 05-ны өдөр албан хаагчид гэрчилгээ авсан.





2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон монгол бичгээр давхар хөтлөн, албан бичиг, тушаалын хэвлэмэл хуудсыг стандартын дагуу хэвлүүлэн 230 тушаал, 2921 албан бичгийг хос бичгээр хөтлөн ажиллаж байна.






### 3.3.3."Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр" биелэлт, үр дүн

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас Төсвийн шууд Захирагчийн Хариуцлагын гэрээ түүний хавсралт болох “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 4 зорилтын 45 арга хэмжээг тусган Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулсан.

Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар зорилтын арга хэмжээ 2.12 дахь хэсэгт “Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон заалт”-ыг тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хавар, намрын улиралд мод тарина. | | | | | | |
| 18. | Арга хэмжээ 2.12.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн тайлагнан ажиллана. | - | Тайлагнасан тоо | 2 | 2 | II, IV улирал | Захиргаа, санхүүгийн хэлтэс |
| 19. | Арга хэмжээ 2.13.Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн НЗДТГ-т тайлагнана. | - | Тайлагнасан тоо | 2 | 2 | II, IV улирал | Ёс зүйн дэд хороо |
| 20. | Арга хэмжээ 2.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, тайлагнана. | - | Тайлагнасан тоо | 2 | 2 | II, IV улирал | Захиргаа, санхүүгийн хэлтэс |
| 21. | Арга хэмжээ 2.15.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | I-IV улирал | Хууль, эрх зүйн хэлтэс |

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 ажлыг төлөвлөн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлан хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдөр 9 зорилтын 22 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж гүйцэтгэл 98.6 хувьтай байна.

Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагааны чиглэлээр болон “Харилцан хүндэтгэе”, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян” аянд нэгдсэн тухай байгууллагаас бэлтгэсэн 1 видео, 12 постер, 4 цуврал, Жендерийн Үндэсний Хорооноос гаргасан 17 мэдээ, мэдээллийг “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” нэртэй фейсбүүк пейж хуудаст байршуулан олон нийтэд түгээн ажилласан.



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”, “Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо” 16 цагийн цахим сургалтад 1 албан хаагч, “Жендэрийн дүн шинжилгээ, ахисан түвшин” цахим сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдсан.

Нийслэл дэх Жендерийн салбар хорооны хуралд 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр 1 албан хаагч оролцсон. Уг хурлаар Жендерийн үндэсний хороо, салбар хороо, дэд салбар хорооны үйл ажиллагааны талаар танилцуулга хийгдэж, цаашид авч хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэн Нийслэлд Олон улсын Жендерийн стандарт, шалгуур үзүүлэлтийн болзол хангах "Жендер сийл" хөтөлбөр хэрэгжүүлэх, төсөв батлуулах арга хэмжээ авахаар үр дүнтэй тохиролцоонд хүрсэн.






Хүүхэд төрүүлэх, асрах чөлөө авсан бага насны хүүхэдтэй 1 албан хаагчийг ажилдаа эргэн томилогдсон даруйд хөдөлмөрийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1.2 дугаар зүйлд заасны албан хаагчийн хүсэлтийн дагуу ажлын цагийг 07.00-15.00 болгон богиносгосон цагаар, хүсэлт өгсөн 5 албан хаагчийн ажил эхлэх, дуусах цагт ажлын уян хатан цагийн зохицуулалт хийж, ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангасан.

Хүүхэд асрах чөлөөг эцэг, эх, хуваалцах талаарх хуулийн заалтыг сурталчлан таниулах танилцуулга бэлтгэж, нийт албан хаагчдад танилцуулсан.

Байгууллагын дэргэд зөвлөл, комиссууд төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль”-д заасны дагуу нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхаар бүрэлдэхүүнийг оруулж байна.

Байгууллагын дэргэд зөвлөл, комиссууд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Залуучуудын Хөгжлийн зөвлөл,
- Өмч хамгаалах байнгын зөвлөл,
- Баримт бичиг, нягтлан шалгах комисс,
- Соёл урлаг, спортын үйл ажиллагааны зөвлөл,
- Эцэг, эхийн зөвлөл,
- Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхаар гишүүдийг оруулсан.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөнд тусгагдсан 11 арга хэмжээний биелэлт 96 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эхний хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 02/1822 дугаар албан бичгээр, жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны 02/2811 дүгээр албан бичгээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын газарт тайлагнасан.

Тус байгууллагын албан хаагчдын 43% нь эрэгтэй, 57% хувь эмэгтэй албан хаагч байна.

# ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

## 4.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

### 4.1.1.Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах чиг үүргийн хүрээнд

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил:

Нийслэлийн Засаг даргаас захирамжаар 2024 онд худалдан авах ажиллагааны эрх шилжсэн 1, 2025 онд эрх шилжсэн 58 захирамж, 3 албан хүсэлтээр 401 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Газрын даргын 65 тушаалаар 118 үнэлгээний хороог байгуулсан.

Бусад албан байгууллагуудаас 3 албан хүсэлтээр ирүүлсэн 3 төсөл, арга хэмжээнд 3 үнэлгээний хороо байгуулагдсан ба эрх шилжин ирсэн даруйд шуурхай зохион байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт тайлант хугацаанд нийт 401 төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээс он дамжих 139 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих 262 төсөл, арга хэмжээ, Захирамжаар өөрчлөлт орж, хөрөнгө татагдаж, хасагдсан ажил 65 төсөл, арга хэмжээ байна.

Нийт 15,448,689,904,900 төгрөгийн төсөвт өртөг бүхий 401 төсөл, арга хэмжээг хуулийн дагуу зарлан зохион байгуулсан байна. Үүнээс:

| Д/д | Товч | Төсөл, арга хэмжээний тоо | Хувь | Төсөвт, өртөг (мян.төг) | Санхүүжих дүн (мян.төг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн | 39 | 9.7% | 33,164,625.7 | 33,153,676.1 |
| 2 | Гэрээ байгуулах эрх олгосон | 2 | 0.5% | 1,800,000.0 | 1,800,000.0 |
| 3 | Гэрээ хийгдсэн | 256 | 63.8% | 5,050,724,541.5 | 2,395,957,523.8 |
| 4 | Захирамжаар хүчингүй болсон | 65 | 16.2% | 1,931,894,100.0 | 1,789,475,600.0 |
| 5 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 5 | 1.2% | 8,391,622,750.0 | 30,137,450.0 |
| 6 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 26 | 6.5% | 13,650,367.6 | 13,410,178.1 |
| 7 | Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа | 4 | 1.0% | 20,862,770.2 | 20,862,770.2 |
| 8 | Хөрөнгө татагдсан | 4 | 1.0% | 4,970,750.0 | 4,970,750.0 |
| | Нийт | 401 | 100.00% | 15,448,689,904.9 | 4,289,767,948.2 |

#### 4.1.1.1.Худалдан авах ажиллагаанд гарсан гомдлын талаар мэдээлэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны явцад 59 гомдол гарснаас:

1. Сангийн яаманд 41 гомдол гарснаас:
   - ✓ Дахин үнэлгээ хийх-24;
   - ✓ Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй-14.
2. Монополын эсрэг газарт 10 гомдол гарснаас:
   - ✓ Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах-6
   - ✓ Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй-4
3. Захиргааны хэргийн шүүхэд 8 гомдол тус тус гарсан.

Дээрх гомдолуудыг тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан.







Гомдлын судалгаанд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, жилийн эцсийн байдлаар 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр тус тус 2 удаа танилцуулж, ТХААХ-ийн албан хаагчдад Хууль, эрх зүйн хэлтсээс зөвлөмж өгсөн.

### 4.1.1.2.Худалдан авах ажиллагааны явцад хуурамч материал ирүүлсэн байж болзошгүй оролцогчийн талаарх мэдээллийг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх

Сангийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 04/47 дугаар албан бичгээр тус газраас зарласан 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад оролцогч 1 компанийн, 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 04/1535 дугаар албан бичгээр тус газраас зарласан төсөл, арга хэмжээнд оролцсон 1 компанийн ирүүлсэн хуурамч байж болзошгүй баримтыг тус тус хүргүүлсэн.

Нийслэлийн удирдах ажилтнуудын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит шуурхай зөвлөгөөнөөс Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар зарласан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт худалдан авах ажиллагаанд оролцоход оролцогчийн ерөнхий болон чадавхын шаардлага, туршлагыг хангах талаар хуурамч баримт бичиг, эсхүл бусад этгээдийн баримт бичгийг өөрчилж тендер ирүүлсэн, худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлагдсан, гэрээнээс татгалзсан, захиалагчийн хяналт тавих явцад гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуй нэгж, хуулийн этгээдийг эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад оруулах үүрэг даалгавар өгөгдсөн. Нийслэлийн нутгийн захиргааны 17 байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 04/545 дугаар албан бичгээр Худалдан авах ажиллагааны явцад хуурамч материал ирүүлсэн, гэрээний үүргээ гүйцэтгээгүй оролцогчийн талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар уламжлуулан Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нотлох баримтын хамт тухай бүр хүргүүлж ажиллахыг зөвлөж зөвлөмж хүргүүлсэн.

2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан нь тогтоогдсон аж ахуйн нэгжийг тендерт

оролцох эрхийг хязгаарлах хүртэлх арга хэмжээ авах үүрэг даалгаврын дагуу захиалагчийн хяналт тавьж ажиллах нийслэлийн нутгийн захиргааны 53 байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 04/2627 дугаар мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн.



9 байгууллагаас гэрээний үүргээ ноцтой зөрчсөн нийт 68 аж ахуйн нэгжийн мэдээллийг, гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан нь тогтоогдсон аж ахуйн нэгж байхгүй талаарх мэдээллийг 27 байгууллагаас тус тус ирүүлснийг нэгтгэн санал, дүгнэлт боловсруулж 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр удирдлагад танилцуулсан.

### 4.1.2.Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” 24/33 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр маягтын дагуу боловсруулан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/06 дугаар захирамжаар батлагдсан.

Мөн НИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 25/50 дугаар тогтоолыг хүлээн авч 04 дүгээр сарын 10-ны өдөр төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) болон байгууллагын цахим хуудас (ub-procurement.mn)-т тус тус нийтэлсэн.

### 4.1.3.Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг цахим системээр батлуулах, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эрх шилжүүлэх, төлөвлөгөө батлах ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэрийн өмнөөс:

- ✓ Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай захирамжийн дагуу 120 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрхийг 141 удаа холбогдох байгууллагуудад цахим системээр шилжүүлсэн.
- ✓ Нийслэлийн нутгийн захиргааны 109 байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системээр батлах ажлыг 285 удаа хийж гүйцэтгэсэн.
- ✓ Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах ажлыг 374 удаа тус тус хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжин ирсэн захирамжийн дагуу цахим системд нийтлэх ажлыг:

2025 оны жилийн эцсийн байдлаар 631 төсөл, арга хэмжээний бүртгэл үүсгэж ажиллав.







Үнэлгээний хорооны систем үүсгэх: Цахим системд үнэлгээний хороо үүсгэх ажлыг нийт 280 удаа хийж гүйцэтгэсэн байна.



Тендерийн баталгаа цуцлах: Цахим системээр тендерийн баталгаа цуцлуулах хүсэлт гаргасан 2024, 2025 оны 1149 аж, ахуйн нэгж байгууллагын тендерийн баталгааг цуцалсан.





Байгууллагын цахим хуудсыг хөтлөх, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд

Вебийг хөгжүүлэх, алдааг засварлах -Цахим хуудасны стандартын шаардлагыг хангаж ажиллуулах үүднээс үндсэн серверийн хэвийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж албан ёсны вирусийн программ суулгасан. Цахим хуудасны домайн нэртэй холбосон Positive SSL сертификат хэвийн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагаag хангахтай холбогдуулан дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

- ✓ Программ хангамжийн засвар үйлчилгээ –60,
- ✓ Техник хангамжийн засвар үйлчилгээ – 60 удаа хийж ажилласан байна.
- ✓ Вебийн контент хөтлөлт: Цахим хуудаст мэдээлэл ub-procurement.mn цахим хуудаст 50 мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй түгээж ажилласан байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны талаар хууль тогтоомж
  - ➢ Жишиг баримт бичиг-8

  Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж
  - ➢ Газрын даргын тушаал-2
- Мэдээ, мэдээлэл
  - ➢ Үйл явдлын мэдээ – 130
- Ил тод байдал цэсэд хамаарах дэд цэсүүдэд:
  - ➢ Хүний нөөцийн ил тод байдал – 10;
  - ➢ Стратеги төлөвлөгөө тайлан - 7;
  - ➢ Төлөвлөгөө тайлан - 6;
  - ➢ Бодлогын бичиг баримт, хууль тогтоомж - 6;
  - ➢ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт тайлан - 4;
  - ➢ Статистик мэдээ – 6.
- Хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ цэсэд хамаарах дэд цэсүүдэд:
  - ➢ Хяналт шалгалтын тайлан, дүгнэлт – 6;
  - ➢ хяналт-шинжилгээ, үнэлгээ – 4.
- Авлигын эсрэг
  - ➢ Авлигын эсрэг 8;
  - ➢ Ёс зүйн дэд хороо -4;
  - ➢ Албан хаагчдын утасны жагсаалт шинэчлэлт – 15;
  - ➢ Холбоо барих - 2





Цахим хуудасны ub-procurement.mn үндсэн болон дэд цэс, цэснүүдийн мэдээллийн баяжилт хийж ажиллав.





- ✓ Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2025 оны жилийн эцсийн тайлан;
- ✓ Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны биелэлтийг тайлагнах хүснэгт (Засгийн газрын 206 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт);
- ✓ Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө;
- ✓ Тусгай шалгалтын зар;
- ✓ Сул орон тооны зар;
- ✓ Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт;
- ✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам;

Авлигын эсрэг: Цахим хуудасны ил тод байдал Авлигын эсрэг цэсэд мэдээллийн баяжилт хийж ажиллав.





- ✓ 2025 оны авлигын эсрэг төлөвлөгөө;
- ✓ Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө эхний хагас жил хэрэгжилт;
- ✓ ХАСУМ хянасан дүгнэлт 8 удаа;

Үйл ажиллагааны ил тод байдал:



- ➢ 2025 оны байгууллагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан;
- ➢ 2025 оны Хариуцлагын гэрээний жилийн эцсийн биелэлт;
- ➢ Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;
- ➢ 2025 оны байгууллагын эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан;
- ➢ 2025 оны хариуцлагын гэрээний эхний хагас жилийн биелэлт;
- ➢ 2024 оны байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн бичвэр тайлан;
- ➢ 2025 оны Аудитын тайлан;
- ➢ Дотоод аудитын 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө;
- ➢ Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилт, үр дүнг нийцлийн тухай тайлан;
- ➢ Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын 2025 оны төлөвлөгөө;
- ➢ Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2022-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт;
- ➢ Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт;
- ➢ Нийслэлиййн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021-2024 болон 2025 оны нэгдүгээр улирлын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан;
- ➢ Байгууллагын 2025 оны нэгдүгээр улирлын өргөдөл гомдлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай;
- ➢ 2025 оны хяналт шинжилгээ үнэлгээ, төлөвлөгөө;
- ➢ 2025 оны нэгдүгээр улирлын өргөдөл, гомдлын тайлан;
- ➢ Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөөний биелэлт;

Тус газрын Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нэртэй албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан дараах мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэсэн.

- ➢ Тендерийн нээлтийг “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” хуудсаар 99 удаа шууд дамжуулалт хийсэн.
- ➢ Цаг үеийн шинжтэй боловсруулсан нийт 80 удаагийн мэдээ мэдээлэл;
- ➢ Нийслэлд хийгдэж буй цаг үеийн шинжтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухай 590 мэдээг байгууллагын фейсбүүк пейж хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж ажилласан.









Урилга нийтлэх: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” 24/33 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр маягтын дагуу боловсруулан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/06 дугаар захирамжаар батлагдсан.



Байгууллагын цахим хуудас (https://ub-procurement.mn/category/haa-tuluwluguu-tailan/) хэсэгт худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулж, олон нийтэд ил тод мэдээлж ажилласан.





Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 25/50 дугаар тогтоолыг хүлээн авч 04 дүгээр сарын 10-ны өдөр төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг дарга баталсан.

Нээлтийн шууд дамжуулалт: Тендерийн нээлтийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн оролцоотой, ил тод зохион байгуулах ажлын биелэлтийг хангаж 2025 онд нийт 99 удаагийн шууд дамжуулалтыг “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” фейсбүүк хуудсаар зохион байгуулан ажилласан байна.

## 4.2. Байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

### 4.2.1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилт

“2025-2028 онд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, “Хөтөлбөрийн хүрээн үр дүн, шалгуур үзүүлэлт”-ийг 2025 оны 02 дугаар 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 9 зорилтын 22 арга хэмжээг төлөвлөн боловсруулан 2025 оны 02 дугээр сарын 28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжүүлэн ажилласан.



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/12 Улаанбаатар хот

Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл,нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дах заалт, 61 дугаар зүйлийн 61.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/1205 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 7.1, 7.1.14 дэх заалт, Газрын даргын 2022 оны А/136 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 11, 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын "Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр"-ийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тайлагнахад хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (З.Отгонбат)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦЭЦЭГ




Төлөвлөгөөнд 9 зорилтын 22 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- ✓ ННҮГ-тай хамтран ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээнд байнгын хяналт тавьж албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчинг бүрдүүлж ажилласан.
- ✓ Газрын хэмжээнд нийт 49 компьютер, 2 зөөврийн компьютер, 7 surface pro, 12 принтерийг сүлжээнд холбон, хэвийн үйл ажиллагааг ханган, албан хаагчдын ашиглаж буй 35 компьтерт вирусийн программ шинээр суулгаж ажилласан.
- ✓ Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/29 дүгээр албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулах тухай тушаалаар 16,806,000 төгрөгийг ажил, олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахаар шийдвэрлэж, 32 албан хаагчийг багц шинжилгээ оношилгоонд хамруулан ажилласан.
- ✓ УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу тавигдах шаардлагыг бүрэн болон 50 хувь хангасан 16 албан хаагчдад зэрэг, дэв түүний нэмэгдлийг ахиулан буюу шинээр олгуулах саналыг 02 дугаар сарын 19-ний өдөр цахимаар ТАЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, зэрэг дэвийн нэмэгдэл олгосон.
- ✓ Газрын хэмжээнд 34 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны, 23 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдэл,1 албан хаагч мэргэшсний нэмэгдэл, 1 албан хаагч ахлах зэргийн нэмэгдэл, 1 албан хаагч эрх бүхий албан тушаалтны нэмэгдэл, 1 албан хаагч нууц хамгаалах ажилтны нэмэгдэл, 1 албан хаагчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны нэмэгдэл тус тус олгон ажиллаж байна.
- ✓ Газарт үүссэн 8 сул орон тооны захиалагыг ТАЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлснээр сонгон шалгаруулалтыг зарлуулж, удирдах албан тушаал 2, гүйцэтгэх 5 албан тушаалын сул орон тоог нөхөн ажилласан.
- ✓ Бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэн эрх зүйн магистр хөтөлбөрт хамрагдаж буй 2, эрх зүйн бакалавр эчнээ хөтөлбөрт хамрагдаж байгаа 4 албан хаагчид хавар, намрын улиралд хичээл сонголтын хуваарийн дагуу цалинтай чөлөө олгож, суралцах боломжоор хангасан.
- ✓ Төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд (мерит) тогтолцоог хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 1 албан хаагчийг шатлан дэвшүүлсэн.

- ✓ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хөтөлбөрийн биелэлтийг 12 дугаар сарын 15-ны өдрийн 02/2855 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хэлтэст хүргүүлсэн.

### 4.2.2.Албан хаагчид мэдлэг чадвар дээшлүүлсэн байдал

Нийт албан хаагчид дараах цахим болон танхимын сургалт, олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар цахим болон танхимын сургалтад албан хаагчдыг 33 удаа хамруулсан. Үүнд:

- Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагаас зохион байгуулсан 33 төрлийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 213 албан хаагчийг, Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх арга зүйн цахим сургалтад 27 албан хаагчийг хамруулсан.
- Төрийн албаны сургуулийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагчийг хамруулахаар мэдээллийг НЗДТГ-т хүргүүлж, 1 албан хаагч төсвийн зардлаар, 3 албан хаагч хувийн зардлаар хамрагдаж төгссөн бол Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хувийн зардлаар 2 албан хаагч суралцаж байна.
- Бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэн эрх зүйн магистр хөтөлбөрт хамрагдаж буй 2, “Эрх зүйн бакалавр” эчнээ хөтөлбөрт хамрагдаж байгаа 4 албан хаагчид хавар, намрын улиралд хичээл сонголтын хуваарийн дагуу суралцаж байна.
- Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн Пүрэв гараг бүр зохион байгуулсан “7:4:10” цахим мэдээллийн цаг 17 удаагийн арга зүйн сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан.
- 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Хяналт, шалгалт дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах” сургалтад цахимаар;
- 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр “Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбооноос эрхлэн гаргадаг Фидик гэрээ түүний ерөнхий ойлголт” сургалтад НХААГ-ын 720 дугаар хурлын зааланд танхимаар;
- 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Хүннү хотын танилцуулгад Нийслэлийн нутгийн захиргааны төв байр, Б блок, 7 давхрын 201 дугаар өрөөнд танхимаар;
- 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Хууль, эрх зүйн албан хаагчдын дунд зохион байгуулсан сургалтад Нийслэлийн нутгийн захиргааны төв байр, Б блок, 7 давхрын 205 тоотод танхимаар;
- 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга, хэмжээнд танхимаар;
- 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрүүдэд нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан Монгол хэл бичгийн мэдлэг олгох 30 цагийн сургалтад танхимаар
- Байгууллагаас зохион байгуулсан дараах 4 төрлийн сургалтад албан хаагчид хамрагдсан байна. Үүнд:
- 2024 оны Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх сургалтад танхимаар;
- “Үндэсний бичиг”-ийн зохих шатны сургалтад 7 хоног бүр нийт 30 цаг танхимаар;

- “Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ны жишиг гэрээний загварууд болон тэдгээрийн онцлог, хэрэглэх аргачлал” гэрээний сургалтад танхимаар;
- Албан хэрэг хөтлөлтийн Edoc системийн сургалтад нийт албан хаагчид танхимаар;
- Монгол Улсын Ёс зүйн дэд хорооноос ”Төрийн албан хаагчийн Ёс зүйн хууль тогтоомж”, ”Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Ёс зүйн зөрчил бүртгэл хяналтын дэд систем” сэдэвт сургалтад танхимаар;
- Хүсэлтийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын аврах ангийн эмч, гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн албан хаагч “Анхны тусламж”, “Гамшгийн үед аврах ажиллагаа” сэдвээр онол болон практик хосолсон 60 минутын сургалтад танхимаар;
- Төрийн албан хаагчийн ажлын зохион байгуулалт, харилцааны соёл сэдэвт сургалтад танхимаар тус тус хамруулсан.







## ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

“Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэх хөтлөх журам”-ын хэрэгжилтийг хангаж 2025 оны I улирлын байдлаар 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 04/928, 2025 оны II улирлын байдлаар 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 04/1962, III улирлын байдлаар 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 04/2593, жилийн эцсийн байдлаар 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 04/2797 дугаар албан бичгээр 4 удаа хүргүүлсэн.

Нийслэлийн хэмжээнд зарласан төсөл, арга хэмжээний үр дүн, гэрээний мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д оруулсан эсэхэд хяналт тавих ажлын хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд 33 байгууллагад тендер шалгаруулалт зарласан төсөл, арга хэмжээний үр дүн, гэрээний мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д 06 дугаар сарын 13-ны өдрийн дотор бүрэн нийтэлж ажиллах талаар 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 04/1766 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

2025 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт тавихад тендерт шалгарсан оролцогчийн гэрээний мэдээллийг цахим системд амжилттай оруулсан боловч нийтэд ил тод нийтлэгдээгүй талаар 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 04/1978 дугаар албан бичгээр, 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 04/2770 дугаар албан бичгээр тус тус 2 удаа цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллах талаар албан бичиг хүргүүлсэн бөгөөд хариу ирүүлээгүй байна.

Нийт 401 төсөл, арга хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр 100 хувь зохион байгуулж, тендерийн нээлтийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны фэйсбүүк цахим хуудсаар нээлттэй лайв хийн нийтэлж ил тод байдлыг хангаж ажиллан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж иргэдийн мэдэх эрхийг хангаж ажиллаж хэвшсэн байна.




1.Төлөвлөгөө баталгаажуулах: Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/06 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан. Байгууллагын веб хуудас (www.ub-procurement.mn)-ын Тендер-Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан цэс, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn), байгууллагын мэдээллийн самбарт тус тус байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан.

Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 25/50 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан. Төлөвлөгөөг Байгууллагын веб хуудас (www.ub-

procurement.mn)-ын Тендер-Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан цэс, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn), байгууллагын мэдээллийн самбарт тус тус байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан.

Шил ажиллагааны буюу цахим системд (Shilengov.mn)-д 3 удаа төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг оруулж ажилласан. Үүнд:

1 дүгээр улирлын тайланд 87%,

2 дугаар улирлын тайланг 90%,

3 дугаар улирлын тайланг 76%-иар тус тус үнэлэгдсэн. Жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор системээр илгээсэн.

Мөн тайлагналтыг сайжруулахын тулд Мэдээллийн ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээг 1 удаа хийж ажилласан.

## ЗУРГАА. БУСАД МЭДЭЭЛЭЛ

### 6.1.Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл

#### 6.1.1.Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны тайлан, мэдээний цахим системийн хөтлөлтийн талаар

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44, 46 55 дүгээр зүйл, Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу тухайн онд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг батлагдсан маягтын дагуу боловсруулан холбогдох газарт хүргүүлдэг болсон.

Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны тайлан, мэдээний цахим систем (www.report.ub-procurement.mn)-ийг хөтөлж системд Нийслэлийн харьяаны 47 байгууллагын 1804 төсөл, арга хэмжээг оруулсан.

Төсөл, арга хэмжээний явц, үр дүнг харуулбал:

- Гэрээ хийгдсэн-1148;
- Гэрээ байгуулах эрх олгосон-144;
- Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа-26;
- Тендерийн материал хүлээн авч байгаа-86;
- Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа-64;
- Явц, үр дүн оруулаагүй 92;
- Зураг төсөв, ажлын даалгаваргүй-16;
- Үнэлгээний хороо байгуулах ажил хийгдэж байгаа-84;
- Захирамжаар хүчингүй болсон 110;
- Хөрөнгө татагдсан 34 төсөл арга хэмжээ байна.

Нийт зохион байгуулж буй 1804 төсөл, арга хэмжээнээс хөрөнгө татагдсан 34 төсөл, арга хэмжээ, захирамжаар хүчингүй болсон 110 төсөл, арга хэмжээг хасаж, 1660 төсөл, арга хэмжээнээс хэрэгжилтийн хувийг тооцоход 88 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үр дүнг тооцоход худалдан авах ажиллагааны явц, үр дүнг дараах 10 байгууллага тухай бүр Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны тайлан мэдээний цахим системд оруулаагүйээс шалтгаалж байна.

### 6.2.Нийслэлийн хэмжээнд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

Нэг.Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний талаар:

Нийслэлийн хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 1804 төсөл, арга хэмжээг Нийслэлийн нутгийн захиргааны 47 байгууллага зохион байгуулан ажиллаж байна.

Хүснэгт 2.Хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэрээр харуулбал:

| № | Санхүүжилтийн эх үүсвэр | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг (төг) | Санхүүжих өртөг (төг) |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Өөрийн хөрөнгө | 392 | 177,552,543,433.00 | 175,969,012,593.00 |
| 2 | Дүүргийн төсөв | 377 | 216,940,317,260.00 | 215,940,317,260.00 |
| 3 | Нийслэлийн төсөв | 256 | 6,060,175,705,628.00 | 3,335,997,582,132.70 |
| 4 | Урсгал зардал | 244 | 114,640,454,654.00 | 114,640,454,654.00 |
| 5 | Он дамжих (УТ, НТ, НЗСХ, НОНХС, НҮЦС ) | 238 | 8,902,267,217,230.00 | 486,833,952,330.00 |
| 6 | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан | 121 | 36,087,055,100.00 | 34,380,938,000.00 |
| 7 | Нийслэлийн Замын сангийн хөрөнгө | 50 | 103,120,750,243.00 | 103,120,750,243.00 |
| 8 | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан | 49 | 25,584,400,000.00 | 25,584,400,000.00 |
| 9 | Хот тохижилтын бусад зардал | 39 | 13,179,799,110.00 | 13,179,799,110.00 |
| 10 | Улсын төсөв | 29 | 255,803,700,000.00 | 179,134,400,000.00 |
| 11 | Гадаадын зээл тусламжийн хөрөнгө | 5 | 247,736,724,000.00 | 104,817,295,830.00 |
| 12 | Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө | 3 | 828,605,600,000.00 | 828,605,600,000.00 |
| 13 | Засаг даргын нөөц хөрөнгө | 1 | 311,750,000.00 | 311,750,000.00 |
| Нийт | | 1804 | 16,982,006,016,658.00 | 5,618,516,252,152.70 |

Нийслэлийн хэмжээний 1804 төсөл, арга хэмжээг зохион байгуулж буй байгууллагаар харуулбал:

Хүснэгт 3.Нийслэлийн хэмжээний 1301 төсөл, арга хэмжээг зохион байгуулж буй байгууллагаар харуулбал:

| № | Зохион байгуулагч байгууллага | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | 401 | 15,448,867,183,828.00 | 4,388,656,675,468.00 |
| 2 | Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 233 | 93,662,921,530.00 | 89,412,921,530.00 |
| 3 | Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 184 | 93,785,319,980.00 | 93,785,319,980.00 |
| 4 | Баянгол дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 137 | 72,713,070,848.00 | 71,713,070,848.00 |
| 5 | Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 120 | 124,882,983,779.00 | 90,613,492,779.00 |
| 6 | Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 119 | 78,174,633,780.00 | 78,174,633,780.00 |
| 7 | Нийслэлийн Замын хөгжлийн газар | 60 | 109,367,400,000.00 | 92,395,000,000.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 8 | Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ | 56 | 22,885,205,094.00 | 22,885,205,094.00 |
| 9 | Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 53 | 18,083,715,500.00 | 16,377,589,400.00 |
| 10 | Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 50 | 122,586,124,979.00 | 72,982,444,943.70 |
| 11 | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ | 36 | 95,151,614,380.00 | 45,184,614,380.00 |
| 12 | Багачууд хүнс ОНӨААТҮГ | 33 | 7,436,780,950.00 | 7,436,780,950.00 |
| 13 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 32 | 23,746,599,200.00 | 23,746,599,200.00 |
| 14 | Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 32 | 8,108,343,900.00 | 8,108,343,900.00 |
| 15 | Асгат ОНӨААТҮГ | 28 | 4,468,085,800.00 | 4,468,085,800.00 |
| 16 | Зорчигч тээвэр Тав | 27 | 17,752,113,550.00 | 17,752,113,550.00 |
| 17 | Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 25 | 6,271,258,000.00 | 5,263,658,000.00 |
| 18 | Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ | 23 | 12,569,455,140.00 | 12,569,455,140.00 |
| 19 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨААТҮГ | 16 | 3,269,340,000.00 | 3,269,340,000.00 |
| 20 | Бодлогын судалгаа, шинжилгээний төв НТҮГ | 14 | 820,682,350.00 | 820,682,350.00 |
| 21 | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ | 12 | 11,979,000,000.00 | 11,979,000,000.00 |
| 22 | Гэрлэх ёслолын ордон ОНӨҮГ | 10 | 2,119,428,900.00 | 2,119,428,900.00 |
| 23 | Багануур тохижилт | 9 | 915,931,600.00 | 915,931,600.00 |
| 24 | Баянзүрх дүүргийн Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ | 8 | 1,646,133,000.00 | 1,646,133,000.00 |
| 25 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | 7 | 13,632,850,000.00 | 13,632,850,000.00 |
| 26 | Эко хотын тээвэр | 7 | 2,196,637,000.00 | 613,106,160.00 |
| 27 | Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ | 6 | 6,901,478,160.00 | 6,901,478,160.00 |
| 28 | Нийслэлийн Соёлын төв өргөө | 6 | 3,634,500,000.00 | 3,634,500,000.00 |
| 39 | Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ | 6 | 8,430,750,000.00 | 8,430,750,000.00 |
| 30 | ЭМЭЭЛТ ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК НӨААТҮГ | 6 | 2,299,500,000.00 | 2,299,500,000.00 |
| 31 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 5 | 299,258,800,000.00 | 299,258,800,000.00 |
| 32 | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар | 5 | 2,546,082,500.00 | 2,546,082,500.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 33 | Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгж | 5 | 247,736,724,000.00 | 104,817,295,830.00 |
| 34 | Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба | 4 | 471,759,200.00 | 471,759,200.00 |
| 35 | Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ | 4 | 852,802,000.00 | 852,802,000.00 |
| 36 | Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК | 4 | 1,273,958,310.00 | 1,273,958,310.00 |
| 37 | Улаанбаатар энержи | 4 | 242,612,000.00 | 242,612,000.00 |
| 38 | Энэрэл эмнэлэг | 4 | 813,633,000.00 | 813,633,000.00 |
| 39 | Нийтийн тээврийн бодлогын газар | 3 | 259,804,400.00 | 259,804,400.00 |
| 40 | Хүннү хотын захирагчийн ажлын алба | 2 | 680,000,000.00 | 680,000,000.00 |
| 41 | Эрдэнэс баянбогд | 2 | 745,096,000.00 | 745,096,000.00 |
| 42 | Багануур-Ус аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар | 1 | 120,000,000.00 | 120,000,000.00 |
| 43 | Зорчигч тээвэр Дөрөв ОНӨААТҮГ | 1 | 5,318,100,000.00 | 5,318,100,000.00 |
| 44 | Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар | 1 | 96,000,000.00 | 96,000,000.00 |
| 45 | Нийслэлийн Орон сууцны корпораци ХК | 1 | 2,200,000,000.00 | 2,200,000,000.00 |
| 46 | Нийслэлийн Эрүүл мэндийн газар | 1 | 935,900,000.00 | 935,900,000.00 |
| 47 | Улаанбаатар лифт ОНӨҮГ | 1 | 95,704,000.00 | 95,704,000.00 |
| Нийт | | 1804 | 16,982,006,016,658.00 | 5,618,516,252,152.70 |

Хүснэгт 4.Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын мэдээ

| № | Товч тайлбар | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Тендер зарласан | | | | |
| 1 | Гэрээ хийгдсэн | 1148 | 5,777,779,118,992.00 | 3,132,129,185,532.00 |
| 2 | Гэрээ байгуулах эрх олгосон | 144 | 176,970,380,669.00 | 129,730,628,133.70 |
| 3 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 110 | 2,255,784,906,398.00 | 2,075,566,106,398.00 |
| 4 | Явц үр дүн оруулаагүй | 92 | 36,186,898,940.00 | 34,603,368,100.00 |
| 5 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 86 | 67,256,209,427.00 | 60,272,983,327.00 |
| 6 | Үнэлгээний хороо байгуулах ажил | 84 | 31,581,703,514.00 | 30,581,712,514.00 |
| 7 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 64 | 8,429,543,378,718.00 | 64,556,860,918.00 |
| 8 | Хөрөнгө татагдсан | 34 | 29,171,355,900.00 | 25,921,355,900.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 9 | Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа | 26 | 65,626,949,900.00 | 44,172,081,630.00 |
| 10 | Зураг төсөв, ажлын даалгаваргүй | 16 | 112,105,114,200.00 | 20,981,969,700.00 |
| Нийт | | 1804 | 16,982,006,016,658.00 | 5,618,516,252,152.70 |

Нийт зохион байгуулж буй 1804 төсөл, арга хэмжээнээс хөрөнгө татагдсан 34 төсөл, арга хэмжээ, захирамжаар хүчингүй болсон 110 төсөл, арга хэмжээг хасаж, 1660 төсөл, арга хэмжээнээс хэрэгжилтийн хувийг тооцоход 88 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үр дүнг тооцоход худалдан авах ажиллагааны явц, үр дүнг дараах 10 байгууллага тухай бүр Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны тайлан мэдээний цахим системд оруулаагүйээс шалтгаалж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт 16,982,006,016,658.00 (арван зургаан их наяд есөн зуун наян хоёр тэрбум зургаан сая арван зургаан мянга наян зургаан зуун тавин найман төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 5,618,516,252,152.70 (таван их наяд зургаан зуун арван найман тэрбум таван зуун арван зургаан сая хоёр зуун тавин хоёр мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн санхүүжих дүнтэй, 1804 төсөл, арга хэмжээг нийт нутгийн захиргааны 47 байгууллага зохион байгуулж буй талаар “Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны тайлан мэдээний цахим систем”-д бүртгэж, тайлагнасан байна.






Хүснэгт 5.Зураг төсөв, ажлын даалгавар хүргүүлээгүй байгууллагуудын жагсаал:

| Д/д | Захиалагч байгууллага | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 4 | 975,000,000.00 | 975,000,000.00 |
| 2 | Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 3 | 3,463,586,200.00 | 108,000,000.00 |
| 4 | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ | 2 | 108,000,000.00 | 14,182,583,500.00 |
| 5 | Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгж | 2 | 101,670,328,000.00 | 180,000,000.00 |
| 6 | Баянгол дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 1 | 180,000,000.00 | 60,000,000.00 |
| 7 | Зорчигч тээвэр Тав | 1 | 60,000,000.00 | 1,359,800,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | 1 | 1,359,800,000.00 | 70,500,000.00 |
| 9 | Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 1 | 70,500,000.00 | 582,500,000.00 |
| 10 | Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 1 | 4,217,900,000.00 | 975,000,000.00 |
| Нийт | | 16 | 112,105,114,200.00 | 20,981,969,700.00 |

Хоёр.Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн захирамжийн хэрэгжилтийн талаар

Тайлагнах үеийн байдлаар хэрэгжиж байгаа нийслэлийн Засаг даргын 192 захирамжийн 675 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг нийслэлийн нутгийн захиргааны 23 байгууллагад шилжүүлсэн байна.

Захирамжаар эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын нийт 675 төсөл, арга хэмжээг зохион байгуулагч байгууллагаар харуулбал:

Хүснэгт 6.Гэрээ хийгдсэн төсөл, арга хэмжээг зохион байгуулагч байгууллагаар харуулбал:

| Д/д | Зохион байгуулагч | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | 396 | 15,447,866,873,828.00 | 4,387,656,365,468.00 |
| 2 | Нийслэлийн Замын хөгжлийн газар | 60 | 109,367,400,000.00 | 92,395,000,000.00 |
| 3 | Баянгол дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 53 | 15,293,692,348.00 | 15,293,692,348.00 |
| 4 | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ | 36 | 95,151,614,380.00 | 45,184,614,380.00 |
| 5 | Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 29 | 34,307,907,500.00 | 30,057,907,500.00 |
| 6 | Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 26 | 71,328,200,000.00 | 37,058,700,000.00 |
| 7 | Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 12 | 84,723,591,479.00 | 35,119,911,443.70 |
| 8 | Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 9 | 9,335,999,900.00 | 9,335,999,900.00 |
| 9 | Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 8 | 3,896,000,000.00 | 3,896,000,000.00 |
| 10 | Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 8 | 5,312,000,010.00 | 5,312,000,010.00 |
| 11 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | 7 | 13,632,850,000.00 | 13,632,850,000.00 |
| 12 | Нийслэлийн Соёлын төв өргөө | 6 | 3,634,500,000.00 | 3,634,500,000.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 13 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 5 | 299,258,800,000.00 | 299,258,800,000.00 |
| 14 | Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 4 | 4,652,400,000.00 | 3,644,800,000.00 |
| 15 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨААТҮГ | 4 | 2,096,700,000.00 | 2,096,700,000.00 |
| 16 | Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба | 3 | 2,380,000,000.00 | 2,380,000,000.00 |
| 17 | Гэрлэх ёслолын ордон ОНӨҮГ | 2 | 1,600,000,000.00 | 1,600,000,000.00 |
| 18 | Хүннү хотын захирагчийн ажлын алба | 2 | 680,000,000.00 | 680,000,000.00 |
| 19 | Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ | 1 | 512,000,000.00 | 512,000,000.00 |
| 20 | Зорчигч тээвэр Дөрөв ОНӨААТҮГ | 1 | 5,318,100,000.00 | 5,318,100,000.00 |
| 21 | Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар | 1 | 96,000,000.00 | 96,000,000.00 |
| 22 | Нийслэлийн Орон сууцны корпораци ХК | 1 | 2,200,000,000.00 | 2,200,000,000.00 |
| 23 | Нийслэлийн Эрүүл мэндийн газар | 1 | 935,900,000.00 | 935,900,000.00 |
| Нийт | | 675 | 16,213,580,529,445.00 | 4,997,299,841,049.70 |

Хөрөнгө оруулалтын нийт 675 төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэрээр харуулбал:

Хүснэгт 7.Хөрөнгө оруулалтын нийт 675 төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэрээр:

| Д/д | Захиалагч байгууллага | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Улсын төсөв | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 1 | 1,186,700,000.00 | 1,186,700,000.00 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 2 | 15,542,900,000.00 | 15,542,900,000.00 |
| 3 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 20 | 225,855,700,000.00 | 152,821,800,000.00 |
| 4 | Зураг төсөв, ажлын даалгаваргүй | 2 | 5,577,700,000.00 | 1,942,300,000.00 |
| 5 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 2 | 3,016,700,000.00 | 3,016,700,000.00 |
| 6 | Хөрөнгө татагдсан | 2 | 4,624,000,000.00 | 4,624,000,000.00 |
| Нийт | | 29 | 225,803,700,000.00 | 179,134,400,000.00 |
| Нийслэлийн Замын сангийн хөрөнгө | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 3 | 4,849,920,000.00 | 42,194,386,547.00 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 42 | 82,045,595,645.00 | 38,520,773,017.00 |
| 3 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 3 | 12,204,434,598.00 | 12,229,510,679.00 |
| 4 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 1 | 2,000,000,000.00 | 5,655,460,000.00 |
| 5 | Хөрөнгө татагдсан | 1 | 2,020,800,000.00 | 546,020,000.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| Нийт | | 50 | 103,120,750,243 | 103,120,750,243 |
| Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 6 | 2,724,768,531.00 | 2,724,768,531.00 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 27 | 16,040,221,069.00 | 16,040,221,069.00 |
| 3 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 2 | 800,000,000.00 | 800,000,000.00 |
| 4 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 2 | 1,400,000,000.00 | 1,400,000,000.00 |
| 5 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 2 | 120,400,000.00 | 120,400,000.00 |
| 6 | Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа | 5 | 2,656,110,400.00 | 2,656,110,400.00 |
| 7 | Хөрөнгө татагдсан | 5 | 1,842,900,000.00 | 1,842,900,000.00 |
| Нийт | | 49 | 25,854,400,000.00 | 25,854,400,000.00 |
| Он дамжих (УТ, НТ, НЗСХ, НОНХС, НҮЦС) | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 13 | 15,738,422,500.00 | 14,466,950,000.00 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 123 | 127,799,387,330.00 | 81,417,794,930.00 |
| 3 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 49 | 344,158,100,000.00 | 337,863,200,000.00 |
| 4 | Зураг төсөв, ажлын даалгаваргүй | 1 | 70,500,000.00 | 70,500,000.00 |
| 5 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 2 | 8,387,827,700,000.00 | 26,342,400,000.00 |
| 6 | Хөрөнгө татагдсан | 5 | 9,050,649,400.00 | 9,050,649,400.00 |
| Нийт | | 193 | 8,884,644,759,230.00 | 469,211,494,330.00 |
| Засаг даргын нөөц хөрөнгө | | | | |
| 1 | Хөрөнгө татагдсан | 1 | 311,750,000 | 311,750,000 |
| Нийт | | 1 | 311,750,000 | 311,750,000 |
| Нийслэлийн төсөв | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 26 | 85,881,318,449.00 | 39,913,038,413.70 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 192 | 4,250,191,162,363.00 | 1,685,917,918,903.00 |
| 3 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 17 | 1,665,152,610,000.00 | 1,564,262,610,000.00 |
| 4 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 2 | 1,868,250,000.00 | 1,868,250,000.00 |
| 5 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 12 | 37,404,964,816.00 | 32,127,864,816.00 |
| 6 | Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа | 3 | 8,561,000,000.00 | 4,041,500,000.00 |
| 7 | Үнэлгээний хороо байгуулах ажил | 2 | 2,177,600,000.00 | 2,177,600,000.00 |
| 8 | Хөрөнгө татагдсан | 2 | 8,938,800,000.00 | 5,688,800,000.00 |
| Нийт | | 256 | 6,060,175,705,628.00 | 3,335,997,582,132.70 |
| Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө | | | | |
| 1 | Гэрээ хийгдсэн | 3 | 828,605,600,000 | 828,605,600,000 |
| Нийт | | 3 | 828,605,600,000 | 828,605,600,000 |
| Урсгал зардал | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 14 | 20,530,138,089.00 | 20,530,138,089.00 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 15 | 17,767,402,800.00 | 17,767,402,800.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 3 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 1 | 123,185,044.00 | 123,185,044.00 |
| 4 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 51 | 13,595,318,411.00 | 13,595,318,411.00 |
| Нийт | | 81 | 52,016,044,344.00 | 52,016,044,344.00 |
| Хот тохижилтын бусад зардал | | | | |
| 1 | Гэрээ байгуулах эрх олгосон | 1 | 1,517,820,000.00 | 1,517,820,000.00 |
| 2 | Гэрээ хийгдсэн | 12 | 1,800,000,000.00 | 1,800,000,000.00 |
| Нийт | | 13 | 3,317,820,000.00 | 3,317,820,000.00 |

Хүснэгт 8. 675 төсөл, арга хэмжээний явцын мэдээг танилцуулбал:

| № | Товч тайлбар | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Гэрээ хийгдсэн | 416 | 5,339,792,269,207.00 | 2,729,137,433,347.00 |
| 2 | Захирамжаар хүчингүй болсон ажил | 91 | 2,248,170,844,598.00 | 2,067,952,044,598.00 |
| 3 | Гэрээ байгуулах эрх олгосон | 89 | 135,541,779,917.00 | 88,302,027,381.70 |
| 4 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 43 | 51,147,875,923.00 | 45,870,775,923.00 |
| 5 | Хөрөнгө татагдсан | 16 | 26,788,899,400.00 | 23,538,899,400.00 |
| 6 | Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа | 8 | 11,217,110,400.00 | 6,697,610,400.00 |
| 7 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 7 | 8,393,095,950,000.00 | 31,610,650,000.00 |
| 8 | Зураг төсөв, ажлын даалгаваргүй | 3 | 5,648,200,000.00 | 2,012,800,000.00 |
| 9 | Үнэлгээний хороо байгуулах ажил | 2 | 2,177,600,000.00 | 2,177,600,000.00 |
| Нийт | | 675 | 16,213,580,529,445.00 | 4,997,299,841,049.70 |

Нийт зохион байгуулж буй 675 төсөл, арга хэмжээнээс зарлаагүй 119 төсөл, арга хэмжээг хасаж, 556 төсөл, арга хэмжээнээс зарлалтын хувийг тооцоход 98%, үр дүн гарсан төсөл, арга хэмжээний хувийг тооцоход 97%-ийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн болович зураг төсөв, ажлын даалгаваргүй 3, захирамжаар хүчингүй болсон 91, хөрөнгө татагдсан 16 төсөл, төсөл, арга хэмжээ буюу нийт 110 төсөл, арга хэмжээний явц үр дүн зохион байгуулагч байгууллагаас шалтгаалаагүй байна.

### 6.3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн сургалтыг зохион байгуулах үүрэг, даалгавар өгөгдсөний дагуу 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 04/1331 дүгээр албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны 23 байгууллагад “Санал авах тухай” албан бичиг явуулж, ирүүлсэн саналыг нэгтгэн 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Сургалтын төлөвлөгөө”-г батлуулсан.

1.2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр сургалтад Нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллагын 51 албан хаагч хамрагдсан.









2.2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар түншлэл төв ХХК, Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 10 албан хаагчид;





3.2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр “Төрийн худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдвийн хүрээнд Баянзүрх дүүргийн 112 төсөвт байгууллагын 112 төсвийн шууд захирагч, 107 нягтлан бодогч нийт 219 албан хаагч хамрагдсан.


БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Хамтран ажиллах тухай

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2025 оны сургалтын төлөвлөгөөнд санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангаж, ил тод нээлттэй, санхүүгийн зөрчилгүй дүүрэг болох зорилтын хүрээнд төсвийн шууд захирагч болон санхүүгийн ажилтнуудын дунд мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үе шаттай сургалт зохион байгуулахаар тусгасан болно.

Энэхүү төлөвлөгөөний дагуу 2025 оны 09 дүгээр сарын 10-ний өдөр танхимын сургалт зохион байгуулах бөгөөд сургалтын хөтөлбөрийг “Төрийн худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалт, цахим дэлгүүрийн хэрэглээ болон анхаарах асуудлууд” сэдвээр оруулахаар төлөвлөөд байна.

Иймд дээрх сургалтыг амжилттай зохион байгуулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор холбогдох мэргэжилтнийг томилж, бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар
Санхүү, Төрийн сангийн хэлтэс
Хэлтсийн дарга
2025.08.29 10:05



4.Ус сувгийн удирдах газрын захиалгаар 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Худалдан авах ажиллагааны хууль, журам, үйл ажиллагааны үе шат, үнэлгээний хороо ажиллах зарчим, тендерийн баримт бичиг боловсруулах шаардлага, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга, шударга өрсөлдөөн, ил тод байдлыг хангах, техникийн тодорхойлолт боловсруулах арга зүй” чиглэлээр сургалт, мэдээлэл өгч, 5 албан хаагчийн асуултад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгсөн. Нийт 89 албан хаагч хамрагдсан.





5.2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Төлөвлөлт, тайлагналт, шууд худалдан авалт, харьцуулалтын арга, цахим дэлгүүр” сэдвийн хүрээнд Нийслэлийн Бизнес, инновацийн газрын 25 албан хаагч хамрагдаж, 5 албан хаагчийн 10 асуултад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.






Худалдан авах ажиллагааны талаар 4 удаагийн сургалт зохион байгуулахад нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллага, ОНӨӨАТҮГ-1, дүүргийн ЗДТГ-3, дүүргийн нийт 25 байгууллагын 394 албан хаагч хамрагдсан. Дүүргийн худалдан авах ажиллагааны албад, нутгийн захиргааны байгууллагуудаас албан байгууллагын утсаар давхардсан тоогоор 200 удаа, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд давхардсан тоогоор ойролцоогоор 250 удаагийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.









Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.8-д тусгагдсан "Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаанд зөвлөн туслах" ажлын хүрээнд тус газрын даргын мөн оны 09 дүгээр сарын

09-ний өдрийн А/115 дугаар тушаалаар “Дүүргийн худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлын тухай” зөвлөн туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.

Ажлын хэсэг зөвлөн туслах ажлын удирдамжийг боловсруулан газрын даргаар 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр батлуулж, Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албанд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 02/2445 дугаар албан бичгээр удирдамж, ажлын хэсгийн ажиллах хуваарийг хүргүүлсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.8-д тусгагдсан арга хэмжээний дагуу газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/115 дугаар тушаалаар “Дүүргийн худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаанд зөвлөн туслах тухай” ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсэг зөвлөн туслах ажлын удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албанд зөвлөн тусалж, арга зүйгээр хангаж ажилласан.

Ажлын хэсгийн тайлан, зөвлөмжийг 2025 оны 10 сарын 02-ны өдрийн 02/2608 дугаар албан бичгээр Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад хүргүүлсэн.

2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын Б блок байрны 206 тоот хурлын танхимд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын 50 албан хаагчийг оролцуулан дараах агуулгын хүрээнд уулзалт, семинар зохион байгуулж ажилласан. Үүнд:

- “Зөвлөн туслах” ажлын тайлан, зөвлөмж;
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжаар худалдан ажиллагааны эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн;
- Худалдан авах ажиллагааны тайлан мэдээний нэгдсэн систем (www.report.ub-procurement.mn)-ийн бүртгэл, хөтлөлт;
- Сангийн сайдын тушаалаар батлагдсан тендер шалгаруулалтын жишиг баримт бичгүүдэд орсон нэмэлт, өөрчлөлт;
- Тус газраас 2025 онд баримталж буй тендер шалгаруулалтын баримт бичгийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга;
- 2025 онд шинэчлэн баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”;
- 2026 онд худалдан авах ажиллагааг хэрхэн ил тод, нээлттэй, түргэн шуурхай, хэмнэлттэй байдлаар зохион байгуулах талаар тус тус хэлэлцэв.










### 6.3.1.СУРГАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮН МЭДЭЭ

Байгууллагын 2025 сэтгэл ханамжийн судалгааг “Худалдан авах ажиллагааны сургалт” чиглэлээр боловсруулан авч ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны тухай сургалт”-д хамрагдсан албан хаагчдаас судалгааг тухай бүр, 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс сэтгэл ханамжийн судалгааг авсан.

Сургалтад хамрагдсан албан хаагчдаас QR код бүхий google form программаар боловсруулсан 5 асуулгатай сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллалаа. Судалгаанд 104 албан хаагч хамрагдсан байна.

Судалгаанаас үзэхэд сургалтад хамрагдсан албан хаагчдын 86.1% нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хуулийг дагалдан гарсан Сангийн сайдын журмуудын танилцуулга сургалтын талаар мэдлэг, мэдээллийг сайн авсан бол сургалтад хамрагдагсдын 14.9% нь шинэчилсэн хууль, журмын талаар хүлээж байсан мэдлэг, мэдээллээ авч чадаагүй байна.

Сургалтыг сайжруулахын тулд сургагч багш кейс дээр тулгуурлан харилцан ярилцах,

5. Сургалтыг хэрхэн сайжруулах тухай таны 3 санал:

104 responses




сургалтын хугацааг уртасгаж дэлгэрэнгүй тайлбарлах саналыг ирүүлсэн бөгөөд цаашидын сургалтад анхаарч ажиллаж байна.

## ДОЛОО.ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

### 7.1.Дотоодын аудитын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

2025 оны А/82 дугаар тушаалаар “Дотоод аудитын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд 2 зорилтын 5 ажлыг төлөвлөн баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

2

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны .. дугаар сарын ..-ний өдрийн ... дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
ДОТООД АУДИТЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээ | Төсөв (мян.төг) | Гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Дотоод аудит хийх хугацаа | | Хамаарах нэгж, албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хагас жил | Жилийн эцэс | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилго 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн гүйцэтгэл, газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм журмын хэрэгжилт болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж буй байдалд дотоод аудит хийж, хэрэгжилт үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж өгөх удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнг газрын даргын өмнө хариуцна. | | | | | | | |
| Зорилт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал, газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм журмын хэрэгжилтэд дотоод аудит хийж холбогдох дүрэм, журам аргачлалыг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 1. | Газрын даргаас үүрэг болгосны дагуу тодорхой чиглэлээр төлөвлөгөөт бус дотоод аудитыг зохион байгуулах. | - | Тухайлсан аудит хийсэн тоо. Өгсөн зөвлөмж, дүгнэлтийн тоо | Удирдлагаас өгсөн үүргийн дагуу тодорхой чиглэлээр төлөвлөгөөт бус аудитыг нэгээс доошгүй удаа зохион байгуулан Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | - | 07-12 сар | -Дотоод аудитор -Холбогдох албан хаагчид |
| 2. | Газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтэд дотоод аудит хийх. | - | Төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл, хэрэгжилтэд дотоод аудит хийх, | Төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг Удирдлагад танилцуулсан байна. | 06-09 | - | Ажлын хэсэг |

Тайлант хугацаанд 345 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд давхардсан тоогоор 689 удаа хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэхэд дотоод аудит хийж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.3-д “үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих;” чиг үүргийн хүрээнд Дотоод аудитор хяналт тавьж 18 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын мэдэгдэлд зөрчил гарсныг зөрчлийн дүгнэлтээр үнэлгээний хороонд хүргүүлэн зөрчлийг тухай бүр арилгуулсан.

Үнэлгээний хорооны хурлын үеэр үнэлгээний хорооны дарга гишүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан үүрэг, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-д заасны дагуу эрх, үүргийг танилцуулж ажилласан.

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээ хийх. | | | | | |
| Зорилт 2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж гаргах, үр дүнг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд: | | | | | | |
| 4 | Байгууллагын гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай тохиолдолд зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлэх. | - | Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж, сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байх. | Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж, үр дүн, нөлөөг дээшлүүлсэн байна. | 06 сард | 12 сард |
| 5 | Байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | - | Нэгжийн гүйцэтгэлийн хагас жилийн тайланд зөвлөмж өгсөн байх. | Зөвлөмж өгч үйл ажиллагааны үр дүнгийн тайлагналтыг сайжруулах талаар зөвлөмж өгч, үр нөлөөг дээшлүүлсэн байна. | Жилд нэг удаа | |
| 6 | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд үнэлгээ өгөх. | - | Өгсөн үүрэг, даалгаврын тоо, Үнэлгээний дундаж хувь | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, удирдлагад хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн байна. | Тухай бүр | |
| 7 | Газрын Удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд үнэлгээ өгөх. | - | Өгсөн үүрэг, даалгаврын тоо, Үнэлгээний дундаж хувь | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелэлтэд үнэлгээ өгч, удирдлагад хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн байна. | Тухай бүр | |
| 8 | Засгийн газрын гишүүн болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд үнэлгээ өгөх. | - | Гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнг бодитой үнэлсэн байх. | Гэрээний хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж тайлагнасан байдалд хяналт тавьж, үнэлгээ өгсөн байна. | 06 сард | 12 сард |
| Зорилт 3.Бусад чиг үүргийн хүрээнд: | | | | | | |
| 9 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт- | - | 2 удаа | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой зөвлөмж өгч, тайлангийн үр | 05 сард | 11 сард |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгөх. | | | нөлөө, шийдвэрлэлт сайжирсан байна. | | |
| 10 | Албан бичиг шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах. | - | 2 удаа | Албан бичиг шийдвэрлэлтийн тайланд зөвлөмж өгч, тайлангийн үр нөлөө, шийдвэрлэлт сайжирсан байна. | 05 сард | 11 сард |
| 11 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавраар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тоо | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад бодит нөхцөл байдлын талаар танилцуулсан байна. | Тухай бүр | |
| 12 | Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 4 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | - | 1 удаа | Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулж, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлсэн байна. | 01 сард | - |

Тайлант хугацаанд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 3, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрт 2, худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн захирамжийн хэрэгжилтэд 3, байгууллагын гүйцэтгэлийн тайланд 1, зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөө, тайланд 1, албан бичиг шийдвэрлэлтэд 2, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд 2, мэдээллийн ил тод байдалд 1 удаа тус тус хяналт-шинжилгээ хийсэн.

Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгавар болон Удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавар, хууль тогтоомжийн хэрэгжилт, сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

Хяналт-шинжилгээ хийсэн ажлын тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулан ажилласан. Холбоос: https://ub-procurement.mn/category/shinjilgee-unelgee/



# НАЙМ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## 8.1.Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

### 8.1.1.Архивын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Байгууллагын архивын ажлын жилийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 5 арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Архивын хадгаламжийн сан нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын Төв цогцолбор байрны Б блокийн В1 давхрын 8 тоот 52,6 мк хадгаламжийн сан, баримт хүлээн авах өрөө бүхий байранд байрладаг.

Архивын ерөнхий газрын даргын 221 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасан стандартад нийцүүлэн тохижуулсан. Үүнд:

- ✓ Архивын нягтруулсан шүүгээ-2 ширхэг;
- ✓ Төмөр тавиур – 2 ширхэг;
- ✓ Тусгай төрлийн баримтын шүүгээ – 2 ширхэг;
- ✓ Галын булан;
- ✓ Чийг дулаан хэмжигч-1 ширхэг;
- ✓ Ухаалаг камер 4 ширхэг;
- ✓ Ухаалаг цоож-1 ширхэг;
- ✓ Өндөр хүчин чадал бүхий компьютер-2 ширхэг;
- ✓ Хард – 2 ширхэг;
- ✓ Дуу хураагч-1 ширхэг;
- ✓ Баримтын тоос сорогч бүхий бүрэн тоноглогдсон архивын өрөө тасалгаанд цаасан суурьтай 2652, цахим суурьтай 2003 баримт (нийт 4655) найдвартай орчинд хадгалагдаж байна.

Нөхөн бүрдүүлэлт:

2024 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан болон цахим суурьтай баримтаар ХХНЖ-ын индексээр бүрэн бүрдэлтэй, хүчин төгөлдөр баримтаар:

- Байнга хадгалах- 307;
- 70 жил хадгалах-6;
- Түр хадгалах-68;
- Цахим-427 хадгаламжийн нэгжийг акт бүртгэлийн дагуу хүлээн авсан байна.

Баримт ашиглалт:

Тайлант хугацаанд 4 чиглэлээр нийт 713 хадгаламжийн нэгжийг холбогдох албан хаагчид Нийслэл дэх Төрийн аудитын газар, Авлигатай тэмцэх газар, Дотоодын хэрэгцээнд, Улсын үзлэгийн ажлын хэсэгт ашиглуулсан.

Нийслэлийн Засаг даргын “Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/1220 дугаар захирамжийн дагуу газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/96 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан, 3 үндсэн үзүүлэлтийн 87 шалгуурын дагуу төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажилласан. Хуваарийн дагуу 11 дүгээр сарын 14, 17-ны өдрүүдэд архивын улсын үзлэгт хамрагдсан.





### 8.1.2.Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар", “Баримт бичгийн нэр төрөл тодорхойлолт MNS 5140-1:2021”, “Баримт бичгийн бүрдэл тэдгээрт тавигдах шаардлага MNS 5140-2:2021”, “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байршуулахад тавих шаардлага MNS 5140- 3:2021", MNS 6395:2022 “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага”, ”Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

А. Ирсэн бичгийн хүрээнд:

2025 оны жилийн эцсийн байдлаар тус газарт нийт 1942 албан бичиг ирснээс:

Байгууллагаар бүртгэгдсэн 344,

Системээр бүртгэгдсэн 1598 албан бичиг байна.

Үүнээс:

- Хариутай албан бичиг 214,
- Хугацаандаа шийдвэрлэсэн 203,
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 10,
- Судалж байгаа 1 албан бичиг тус тус байна.

Хариугүй албан бичиг 1728 ирснээс 1717 хугацаандаа хааж, хугацаа хэтэрсэн 3, судалж байгаа 8 албан бичиг тус тус байна. Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 2,32 байна.

Тайлант хугацаанд ирсэн бичгийг удирдлагуудад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчдад шилжүүлэн, бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан.

Хүснэгт 8.Албан бичиг шийдвэрлэлтийн явцын мэдээ

| № | Агуулга | | Тоо ширхэг |
|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 |
| 1 | Нийт ирсэн бичгийн тоо | | 1942 |
| 2 | Үүнээс | Хариутай | 214 |
| 3 | | Хариугүй | 1728 |
| 4 | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн бичгийн тоо | | 13 |

| 1 | 2 | 3 |
|---|---|---|
| Нийт ирсэн хариугүй бичгийн шийдвэрлэлтийн хувь | | 99,91% |
| Нийт ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь | | 97,65% |
| Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь | | 98,10% |

Б.Явсан бичгийн хүрээнд:

Тус газраас нийт 2921 албан бичиг явуулсан ба үүнээс хариутай 281, хариугүй 2640 албан бичиг явуулж ажилласан байна. Шийдвэрлэлтийн байдал 100 хувь байна.

В. Зөрчлийн мэдээлэл:

Тайлант хугацаанд “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар”-т стандартын зөрчил 11, систем ашиглалтын зөрчил 6, шийдвэрлэх хугацааны зөрчил 1, шийдвэрлэлтийн зөрчил 6 тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 3. Ирсэн явсан бичгийн харьцуулалт (2020 оноос 2025 оны жилийн эцэс)




Зураг 4. А,Б тушаал (2020 оноос 2025 оны жилийн эцэс)




### 8.1.3.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын албан хаагчдаас нийт 26 өргөдөл, иргэнээс 1, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 7 11-11 төвөөс 3 өргөдөл ирж нийт 37 өргөдлийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд хүсэлт 36, гомдол 1 бүртгэгдсэн байна.

Ирсэн 37 өргөдлийг хариу өгсөн хэлбэрээр нь ангилбал:

- ✓ Программ хангамж + мессежээр хариу өгсөн 5;
- ✓ Программ хангамж + мессеж + утсаар хариу өгсөн 21;
- ✓ Программ хангамж + мессеж + албан бичгээр хариу өгсөн 11.

Өргөдлийг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- ✓ Өргөдөл гаргагчийн талд шийдвэрлэсэн өргөдөл 32,
- ✓ Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл 5 өргөдөл тус тус байна.

Өргөдлийг ангилан авч үзвэл:

Хүснэгт-9 Өргөдлийн дэлгэрэнгүй мэдээлэл

| № | Ангилал | Өргөдлийн тоо | Өргөдлийн хувь |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Цалинтай чөлөө хүсэх тухай | 8 | 21.62% |
| 2 | Ажлаас чөлөөлөгдөх тухай | 6 | 16.22% |
| 3 | Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай | 8 | 21.62% |
| 4 | Ажилд орох тухай | 4 | 10.81% |
| 5 | Жирэмсний амралтын тухай | 3 | 8.11% |
| 6 | Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай | 2 | 5.41% |
| 7 | Ээлжийн амралт авах тухай | 1 | 2.70% |
| 8 | Дүүргийн Засаг даргын бодлого, үйл ажиллагааны тухай | 1 | 2.70% |
| 9 | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай | 1 | 2.70% |
| 10 | Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай | 1 | 2.70% |
| 11 | Авто зам, гүүрийн ажлын төлөвлөлтийн тухай | 1 | 2.70% |
| 12 | Цалингүй чөлөө хүсэх тухай | 1 | 2.70% |
| Нийт өргөдлийн дүн | | 37 | 100% |

Байгууллагад ирсэн өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 6 цаг 40 минут байна. Энэ нь өмнөх оны жилийн эцсийн өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас 1 хоногоор өссөн үзүүлэлттэй байна. Учир нь тус байгууллагын чиг үүргийн дагуу шууд харьяалан шийдвэрлэхгүй, бусад байгууллагатай хамтран шийдвэрлэх өргөдөл ирсэнтэй холбоотой байна.

Өргөдлийг шийдвэрлэсэн хугацаагаар нь авч үзвэл:

- ✓ 1-5 хоногт шийдвэрлэсэн 32 өргөдөл,
- ✓ 6-10 хоногт шийдвэрлэсэн 3 өргөдөл,
- ✓ 11-15 хоногт шийдвэрлэсэн 1 өргөдөл,
- ✓ 30 хоногт шийдвэрлэсэн 1 өргөдөл тус тус байна.

Тайлант хугацаанд өдөрт нь багтаан шилжүүлээгүй 2 зөрчил, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 5, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил, нийт 8 зөрчил үүссэн байна. Зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлахад шинээр томилогдсон албан хаагч цахим системийг тухай бүр шалган өргөдөл шилжүүлдэг талаар ойлголтгүйгээс болсон байна. Цаашид системд өргөдөл ирсэн эсэхийг тухай бүр шалгаж, өргөдлийг шилжүүлж байх талаар арга зүйн зөвлөгөө өгч, өргөдөл шилжүүлсэн нэгжийн удирдлагыг тухай бүр хяналт тавьж ажиллахыг удирдлагаас үүрэг болгосон.

Өргөдлийг тухай бүр хүлээн авч, бусад байгууллагатай хамтран шийдвэрлэх өргөдлийг тухайн байгууллагад өргөдлийг хүргүүлэн, тал бүрээс нь судлан, өргөдөл гаргагчид хариу өгч, холбогдох нотлох баримтыг цахим системд хавсарган шийдвэрлэсэн байна. Эдгээр нь:

ИРГЭН Б МӨНГӨНШАГАЙД

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Хүсэлтийн хариу хүргүүлэх тухай

Тус газраас "Шинэ зуун модын бүтээн байгуулалтын зэвний эалжийн авто замын ажлын зураг төсөв" (НХААГ/20250103567) төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зарлаж, тендер нээх хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр байхаар зарлалд тусгасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт "Захиалагч тендер шалгаруулалттай холбоотой хуульд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл сонирхогч этгээд, оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.", 57.7 дахь хэсэгт "Захиалагч энэ хуулийн 28.1-д заасан шийдвэр гарснаас хойш гомдол хүлээн авахгүй." гэсэн хуулийн зохицуулалттай.

Иймд захиалагчид гомдол гаргах бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу гомдол гаргахыг үүгээр мэдэгдэж байна.

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Техникийн тодорхойлолт шинэчлэн ирүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргаас 2025 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн А/107 дугаар захирамжаар эрх шилжүүлсэн Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд санхүүжих "Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн угаагч, ариутгагч тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээний тендерийг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зарлаж мөн оны 03 дугаар сарын 17-ны өдөр нээхэд тус тендерт 2 оролцогч үнийн санал ирүүлсэн боловч шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй байна.

Иймд дээрх төсөл, арга хэмжээний амжилтгүй болсон шалтгаан нь техникийн тодорхойлолтод байна гэж үнэлгээний хороо үзсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалт, мөн хуулийн 12 дугаар зүйлийн дагуу техникийн тодорхойлолтыг дахин боловсруулж ирүүлнэ үү.

Тендер сонирхогч этгээд болон Засгийн газрын 1111 төвд хандсан иргэний гомдлыг хавсаргав.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ХОЁРДУГААР ХЭЛТЭС

2025.02.04 № 30в2-2/742

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Б.Санчир нь Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэст Баяннуур дэжис ХХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, залилуулсан гэх гомдол мэдээллийг 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусч, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлсэн болохыг үүгээр мэдэгдье.

Цагдаагийн ерөнхий газар
Хан-Уул дүүргийн цагдаагийн газар
Хоёрдугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга
Сүхбаатар Сүхбаатар
2025.02.05 09:05

Системд өргөдөл шилжүүлсэн албан хаагч 1 өргөдлийг хаахдаа иргэний талд шийдвэрлэсэн боловч системд "боломжгүй хариу өгсөн" гэж төлөв буруу сонгон шийдвэрлэсэн байна. Цаашид өргөдлийг шийдвэрлэж хаахдаа шийдвэрлэлтийн төлөвийг зөв сонгон хариу өгч байхыг холбогдох албан хаагчид анхаарууллаа.

Өргөдлийн шийдвэрлэлтийн тайланг улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 4 удаа хугацаанд нь тайлагнаж, ажилласан байна.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВД

Тус газрын 2025 оны нэгдүгээр улирлын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

Гарын үсэг: 2025.03.31 18:27

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВД

Тус газрын 2025 оны хоёрдугаар улирлын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

Гарын үсэг: 2025.06.30 11:51

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВД

Тус газрын 2025 оны гуравдугаар улирлын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

Гарын үсэг: 2025.09.29 18:25

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВД

Тус газрын 2025 оны жилийн эцсийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

Гарын үсэг: 2025.12.19 15:41

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэн улирал бүр тайланг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулахаас 4 удаа тухай бүр оруулж, олон нийтэд мэдээллэн ажилласан.




## 8.2.Төсөв, санхүү үйл ажиллагааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Байгууллагын батлагдсан төсвийг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах хүрээнд:

Тайлагнах үеийн байдлаар төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэл 90,0 хувьтай байна. Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс баталсан 2,173,687.5 төгрөгийн санхүүжилтээс 1,957,672.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 216,015.2 мянган төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, Үндсэн үйл ажиллагааны орлого 22,500.0 мянган төгрөг төлөвлөсөнөөс 57,370.0 мянган төгрөгийн орлого орж 34,870.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах ажлын 7 арга хэмжээг төлөвлөгөөнд тусган боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд өр, авлага үүсгэхгүй ажиллаж, төсвийн гүйцэтгэлийг хугацаанд нь сар бүр буюу нийт 12 удаа НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст тайлагнасан.

## 8.3.Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж, 2025 онд ажиллах ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

“Өмч хамгаалах байнгын зөвлөл” нь 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/73 дугаар тушаалаар зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь өмч хөрөнгөтэй холбоотой аливаа шийдвэрийг хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэж, тухай бүр Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүсэлт гарган шийдвэрлүүлж, шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Тайлант хугацаанд доорх 6 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Газрын өмчийг зөв зохистой, ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан ажилласан.

"Яармаг дахь Хангарди” ордон руу шилжин нүүсэнтэй холбогдон шинээр ирсэн 124 ширхэг тавилга эд хогшилд бүртгэл хийн төлөвлөгөөний дагуу 35 албан хаагчдад картлан

хариуцуулж, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдал, шилжилт хөдөлгөөнд тухай бүр хяналт тавьсан.

Мөн шаардлага хангахгүй машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг актлах саналыг НӨХГ-т хүргүүлж, зөвшөөрөл авч шийдвэрлэсэн.

Нийслэлийн Өмчийн харилцааны газартай Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байгуулсаны дагуу гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. НӨХГ-ын дарга болон газрын дарга солигдох бүрд гэрээг шинэчилж хийдэг тул гэрээ өөрчлөгдөөгүй байна.

Хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүрд өөрчлөлтийг бүртгэж, хяналт тавьж ажилласан. Байгууллагын хэрэгцээнд шинээр авсан ашиглагдаж байгаа нийт 124 ширхэг 16 нэр төрлийн эд хөрөнгийг коджуулж 35 эзэмшигчид нь эд хариуцагчийн картаар хүлээлгэн өгч ажиллаж байна.


НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2. Тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 30-ны өдрүүдэд хийж, ... тайлан, тооллогын бүртгэлийг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр ...

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Эргэлтийн бус хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад шилжүүлэх тухай-5, актлах тухай-2, хөрөнгө бүртгэж авах тухай-2 албан бичиг тус тус хүргүүлэн шийдвэрлүүлсэн байна.

Хөрөнгийн хөдөлгөөн гарах бүрт НӨХГ-аас зөвшөөрөл авч, хууль журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд НЗДТГ-аас хүлээж авсан 6 нэр төрлийн 103 ширхэг хөрөнгийг бүртгэн авч коджуулж ажилласан бөгөөд бараа материалыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэн Газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/118 тушаалын дагуу акталж данс бүртгэлээс хассан.

Нийслэлийн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төвд 4 нэр төрлийн 15 ширхэг машин тоног төхөөрөмж хөрөнгийг балансаас балансын хооронд шилжүүлэн ажилласан бөгөөд тухайн газраас 1 нэр төрлийн 5 ширхэг машин тоног төхөөрөмж хүлээн авч бүртгэсэн.

Тайлант хугацаанд машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил болон хангамжийн материалыг актлах саналыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, НӨХГ-т албан хүсэлт хүргүүлсэн.

Нийслэлийн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төвд дөрвөн нэр төрлийн арван таван ширхэг машин тоног төхөөрөмжийг балансаас балансын хооронд шилжүүлэн ажилласан.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Umch.sgov.mn программ-д өмчийн хөдөлгөөнийг бүртгэн, үлдэгдлийг Санхүүгийн тайланд бүртгэлтэй тулган, шинээр хүлээн авсан хөрөнгийн зургийг байршуулж ажилласан. Эргэлтийн бус хөрөнгийн санхүүгийн тайлангийн үлдэгдэл Нийслэлийн өмчийн харилцааны газрын Umch.sgov.mn программын бүртгэлийн дүнтэй таарсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын хэрэгцээнд ашиглагдаж байгаа эд хөрөнгийг коджуулж эзэмшигч тус бүрт хариуцуулан ажилласанаар албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн бүртгэл, хяналт сайжирсан.

Газрын өмчийг зөв зохистой, ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, шаардлагатай бараа материал болон сэлбэг хэрэгслээр хангаж ажилласан.

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын бүртгэлийн цахим системд шивж баталгаажуулахаар бэлтгэл ажлыг бүрэн хангасан.

## ЕС.БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ЗӨВЛӨЛ, КОМИССУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 9.1.Эцэг, эхийн зөвлөл

“Эцэг, эхийн зөвлөл” нь 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/76 дугаар тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулагдсан.

Байгууллагын “Эцэг, эхийн зөвлөл”-ийн 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 05 дугаар сарын 26-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАХИРГАА САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТЦЭЦЭГ
2025 оны 05 дугаар сарын 26

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
“ЭЦЭГ, ЭХИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 05 дугаар сарын 26 — Улаанбаатар хот

| Д/д | Арга хэмжээ | Төсөв (мян.төг) | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго: Албан хаагчдын гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, хүүхэд гэр бүлд ээлтэй халуун дулаан уур амьсгал бий болгох. | | | | | | |
| Зорилт: 1.Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/32 тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр | | | | | | |
| 1 | 1.1.Албан хаагчдын хүүхдүүдийн судалгааг шинэчлэх; | - | Албан хаагчийн тоо, Хүүхдийн тоо | Хүүхдийн судалгааг шинэчилсэн байна. | II, IV улирал | Нарийн бичгийн дарга Ц.Амармандах |
| 2 | 1.2.Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах; | - | Хэрэгжилтийн хувь | Холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна. | II, IV улирал | Нарийн бичгийн дарга Ц.Амармандах |
| 3 | 1.3.Арга хэмжээ зохион байгуулах. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, | Нөлөөллийн ажил хийгдсэн байна. | II, IV улирал | Дарга Г.Бүрэнжаргал Гишүүн Б.Энхбаяр |
| Зорилт: 2.Гэр бүлийн боловсрол, хүүхэд хөгжлийг дэмжих чиглэлээр | | | | | | |
| 4 | “Ирээдүйн иргэдэд төрийн үйлчилгээ, ажил мэргэжлийн онцлогийг таниулах, гэр бүлийн үнэ цэнийг дэмжих өдөрлөг” зохион байгуулах. | 2,000,000 | -Хамрагдсан хүүхдийн тоо.<br>-Зарцуулсан мөнгөн дүн | Ажил мэргэжлийн онцлогийг таниулсан байна. | III-IV улирал | Гишүүн А.Мөнхзаяа, С.Цэрмаа. |
| 5 | Хүүхдүүдийг “Science cafe”-д урих. | 1,700,000 | -Хамрагдсан хүүхдийн тоо.<br>-Зарцуулсан мөнгөн дүн | Хүүхдүүд сэтгэн бодох, мэдлэг чадвараа дээшлүүлэн насны онцлогт тохирсон, сонирхолтой зүйлтэй танилцаж, өөрсдийн хоббитой болсон байна. | III-IV Улирал | Гишүүн Ч.Туяацэцэг, С.Цэрмаа |
| 6 | Хүүхэд хамгааллын бодлого батлуулах. | - | Бодлого батлуулж, албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулсан байх. | Бодлогыг хэрэгжүүлж ажилласан байна. | II-IV улирал | Гишүүн М.Номин-Эрдэнэ |
| Зорилт: 3.Бусад үйл ажиллагааны чиглэлээр | | | | | | |
| 7 | Дээд газраас ирүүлсэн зөвлөмж, зааврын дагуу ажил зохион байгуулах. | - | Хэрэгжилтийн хувь | Зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн ажиллаж, холбогдох газарт тайлагнасан байна. | II-V улирал | Эцэг, эхийн зөвлөл |
| 8 | Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг холбогдох газарт тайлагнах. | - | Хугацаанд нь хүргүүлсэн байх. | Төлөвлөгөөний хэрэгжилт (бичвэр тайлан)-ийг 2 удаа тайлагнасан байна. | II, IV Улирал | Дарга Г.Бүрэнжаргал, Нарийн бичгийн дарга Ц.Амармандах |
| 9 | Зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах. | - | Цахим хуудаст байршуулсан байх. | 2 удаа мэдээлсэн байна. | II, IV Улирал | Эцэг, эхийн зөвлөл |

C:\Users\DELL\Downloads\Эцэг эхийн зөвлөл төлөвлөгөө 2025_1.docx

Гэр бүлийн боловсрол, хүүхэд хөгжлийг дэмжих чиглэлийн дагуу газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/84 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг батлан дотоод сүлжээ болон мэдээллийн самбарт байршуулж ажилласан.

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН:
ДАРГА Г.БҮРЭНЖАРГАЛ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.АМАРМАНДАХ

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 26 өдөр Дугаар А/84 Улаанбаатар хот

Хүүхэд хамгааллын бодлогыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хүүхэд хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дах хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1205 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 7.1.1 дэх заалт, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны даргын 2025 оны А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хавсралтаар батлсугай.

2.Хүүхэд хамгааллын бодлогыг нийт албан хаагчид мөрдөн ажиллаж, бүтэн жилээр тайлагнахыг Эцэг, эхийн зөвлөл (Г.Бүрэнжаргал)- д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦЭЦЭГ

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/84 дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг, эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын түвшинг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

Хоёр. Зорилго

2.1.Албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, салбарын хэмжээнд байгууллагын нөөц, байгууллагын онцлогт нийцүүлэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллахад оршино.

Гурав.Үндсэн зарчим

3.1.Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзнэ.

3.2.Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

3.3.Аливаа үйл ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Дөрөв. Хамрах хүрээ

4.1 Энэхүү баримт бичиг нь албан хаагч, үндсэн болон гэрээт ажилтан, сайн дурын ажилтан, дадлагажигч ажилтан, оюутан, хамтран ажиллах байгууллагын ажилтнуудад хамаарна.

Тав. Ажилтнуудын ёс зүйн дүрэм

5.1.Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

5.2.Ажилтан, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээнд хориглох зүйлс:

5.2.1. Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх;

5.2.2.Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх;

5.2.3.Хүүхэд, гэр бүлийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэл үйлдэх;

5.2.4.Бусдыг садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг ярих;

5.2.5.Хүүхдийн дэргэд харааж хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх;

5.2.6.Хүүхдийг ялгаварлан харилцах;

5.2.7.Хүүхэд хүчирхийлэлд өртөж, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд мэдээлэхгүй орхих;

5.2.8.Зохисгүй хувцаслах, бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдал гаргах;

5.2.9.Чанарын баталгаагүй, муудсан, хориглосон, чихэрлэг хоол хүнсээр хангах;

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 30 албан хаагчийн 0-16 насны 56 хүүхдэд гарын бэлэг өгөх ажлыг зохион байгуулсан.






## 9.2.Соёл урлаг спортын зөвлөлийн үйл ажиллагааны талаар

Байгууллагын дэргэдэх "Соёл урлаг, спорт зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг нь 2025 оны А/21 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 арга хэмжээг тусган 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр батлан, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

